# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (448)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага (APSCO)-ын конвенцийг соёрхон батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай*
- *Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2006 оны тавдугаар сарын 21 №19 (448)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


248. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага (APSCO)-ын конвенцийг соёрхон батлах тухай 530

249. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай 530


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


250. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Дугаар 26 530

251. Ж.Батмөнх агсны ар гэрийн ахуй хангамжийн тухай Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 27 535

252. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/03 дугаар дүгнэлтийн тухай Дугаар 28 535

253. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 29 535

254. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/04 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 30 535

255. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох тухай Дугаар 31 536

256. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг чөлөөлөх тухай Дугаар 32 536

257. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай Дугаар 33 536

258. Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 34 537

259. Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 35 537

260. Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 36 538

261. Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 37 539

262. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 38 539

263. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай Дугаар 39 539


### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


264. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (Засгийн газрын 2006 оны 57 дугаар тогтоолын хавсралтын үргэлжлэл) 540

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр | Улаанбаатар хот

### АЗИ, НОМХОН ДАЛАЙН САНСРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА (APSCO)-ЫН КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2005 оны 10 дугаар сарын 28-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо гарын үсэг зурсан Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага (APSCO)-ын конвенцийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр | Улаанбаатар хот

### ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3 дахь хэсгийн "3 жилийн дотор", 396.4 дэх хэсгийн "1 жилийн дотор" гэснийг "10 жилийн дотор" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 26 | Улаанбаатар хот

### Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгаль орчны экологийн тэнцлийг хангах, унаган төрхийг хадгалах, хамгаалах болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Ховд аймгийн Мөнххайрхан сум, Баян-Өлгий аймгийн Булган сумын хил залгаа нутагт орших Мөнххайрхан уул, түүний орчмын газар нутгийг Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын ангиллаар, Өвөрхангай, Архангай аймгуудын зааг нутагт орших Орхоны хөндий, түүний орчмын газар нутгийг Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын ангиллаар, Увс аймгийн Тэс сумын Тэсийн голын сав газрыг байгалийн нөөц газрын ангиллаар, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутагт орших Даян Дээрхийн орчмын газар нутгийг байгалийн дурсгалт газрын ангиллаар тус тус улсын тусгай хамгаалалтад авсугай.

2.Мөнххайрханы ба Орхоны хөндийн байгалийн цогцолборт газруудын хилийн заагийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батласугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 26 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

### Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хилийн заағ

Баруун захын цэг нь Баян-Өлгий аймгийн Булган сумын Булган голын зүүн хэсэгт орших 2711.6 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойшоо 2607.0, 2961.0, 3586.0 тоот өндөрлөгүүдийг дайран Баян-Өлгий, Ховд аймгийн хилийн заагт орших 3212.0 тоот өндөрлөг хүрч түүнээс зүүн урагш мөн хилийн дагуу явсаар 3566.0, 3703.1 тоот өндөрлөгүүдийг дайран Хар онийн даваа /3086.0/, түүнээс зүүн тийш 3267.0 тоот өндөрлөг, зүүн урагшаа Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан, Баян-Өлгий аймгийн хилийн заагийн уулзварт орших Машийн даваа /3125.0/ хүрнэ. Түүнээс зүүн тийш Мөнххайрхан, Дуут сумдын хилийн заагт орших / 3070.0 / 91° 34' 42", 47° 15' 38", / 3215.0 / 91° 36' 33", 47° 16' 27" тоот өндөрлөгүүдийг дайрч зүүн урагш мөн хилийн заагт орших / 3135.0 / 91° 40' 12", 47° 15' 48" тоот өндөрлөг, түүнээс урагш эргэж / 2983.0 / 91° 41' 01", 47° 14' 50" тоот өндөрлөг, түүнээс Хүрэн хагт уул / 3066.0 / 91° 41' 41", 47° 14' 10" түүнээс зүүн урагшаа Алаг уул /2941.0/ 91° 47' 26", 47° 11' 41" түүнээс урагшаа / 2145.0 / 91° 47' 12", 47° 09' 53" тоот өндөрлөг, түүнээс баруун урагшаа орших / 3267.0 / 91° 38' 52", 47° 08' 58" тоот өндөрлөг, түүнээс урагшаа Хатуу дурульч уул /3221.0/ 91° 37' 55", 47° 07' 10" түүнээс урагшаа / 3014.0 / 91° 38' 15", 47° 04' 41", / 2964.0 / 91° 38' 26", 47° 02' 13", / 3202.0 / 91° 37' 01", 46° 59' 02" тоот өндөрлөгүүдийг дайран / 3407.0 / 91° 37' 03", 46° 56' 10" тоот өндөрлөг хүрэн, түүнээс зүүн урагш эргэж / 3185.0 / 91° 38' 36", 46° 55' 05" тоотыг дайран Хөх нуурын хойд цэг /2810.0/ 91° 45' 06", 46° 51' 54" тоотыг дайран түүнээс зүүн урагш орших / 3542.0 / 91° 50' 21", 46° 49' 47" тоот өндөрлөг, түүнээс зүүн

урагш Дамбын уул /3369.0/ 91° 57' 12", 46° 48' 04", Бөөрөг нуурын хөтөл /3145.0/ 91° 58' 48", 46° 46' 23" түүнээс баруун урагш эргэж Мөнххайрхан, Мөст сумдын хилийн заагт орших Хар гуя уул /3586.0/ 91° 57' 30", 46° 43' 55" түүнээс баруун урагш Мөнххайрхан, Үенч, Мөст сумдын хилийн заагийн уулзварт орших Хар ац уул /3965.0/ 91° 56' 52", 46° 41' 35" хүрээд баруун тийш эргэж Баян-Өлгий, Ховд аймгийн хилийн зааг дээр орших Хар ацын даваа / 3421.0/ 91° 55' 20", 46° 41' 19" хүрч түүнээс ялимгүй баруун урагш хоёр аймгийн хилийн заагийн дагуу Харцагтын өндөр / 3420.0 / 91° 55' 01", 46° 39' 24" Улаан сайрын нуруу / 3392.0 / 91° 54' 21", 46° 36' 54" хүрч баруун тийш эргэж Арцат уул / 3502.8 / 91° 47' 52", 46° 37' 27" тэндээсээ Цүнхэл, Арцат голын бэлчир хүрч Улаан богоч уул / 3092.8 / 91° 37' 34", 46° 37' 00" Зуслангийн нуруу / 3244.0 / 91° 35' 21", 46° 35' 33" хүрээд түүнээс баруун хойш эргэж хоёр аймгийн хилийн заагт орших Хөх хөтөл 91° 33' 14", 46° 36' 46", / 3043.5 / 91° 31' 00", 46° 38' 34" тоотуудыг дайрч мөн хилийн заагт орших Хөшөөтийн даваа хүрч тэндээс хойшоо эргэж / 2856.7 / 91° 30' 31", 46° 39' 39" тоот өндөрлөг хүрээд түүнээс баруун хойшоо Чачиртын голын / 2181.0 / 91° 26' 29", 46° 41' 27" тоот, /2901.0/ 91° 25' 06", 46° 42' 21" /2165.0/ 91° 22' 48", 46° 43' 22", / 2624.0/ 91° 21' 33", 46° 47' 24", /2701.4/ 91° 18' 00", 46° 49' 54", /2601.0/ 91° 13' 50", 46° 52' 28", /2737.2/ 91° 10' 48", 46° 55' 09", /2846.5/ 91° 07' 59", 46° 57' 15", /2554.8/ 91° 03' 47", 47° 01' 54" тоот өндөрлөгүүд, түүнээс Булган гол, Ёлтын голын бэлчир дэх /2040.0/ 91° 02' 28", 47° 04' 20" тоотыг дайран /2711.6/ 91° 01' 39", 47° 07' 17" өндөрлөгт хүрнэ.

**МӨНХХАЙРХАНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ**



*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 26 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

## Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хилийн зааг

Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хилийн хамгийн хойд цэг болох Их, Бага Арцатын голын уулзвар дахь 102° 43' 57", 47° 13' 20" солбицол бүхий цэг, түүнээс хойш Бага Саруул уул (1861.5) 102° 43' 22", 47° 14' 55" түүнээс баруун хойш Майхан уул (1756.0) 102° 39' 40", 47° 17' 29" түүнээс баруун хойш Өвөрхангай аймгийн Хотонт, Хархорин сумдын хилийн заагт орших Тэмээн хүзүүний гарам дахь 6 дугаар шонг дайран 1489.5 тоот 102° 31' 51", 47° 22' 53" түүнээс зүүн хойш Цолмон толгой (1574.3) 102° 34' 24", 47° 26' 19" түүнээс хойш Дойт уул (1415.5) 102° 31' 58", 47° 32' 31' түүнээс зүүн хойш Өгийнуур, Хотонт, Хашаат сумдын хилийн заагийн уулзвар дахь Манхан элс (1373.5) 102° 40' 28", 47° 34' 45" түүнээс чанх зүүн зүгт орших 102°45'30", 47°35'00" солбицол бүхий цэг, түүнээс зүүн тийш 4 км-т орших 102°48'30", 47°35'00" солбицол бүхий цэг, түүнээс зүүн хойш Хүрэн чулуут уул (1533.7) 102° 49' 43", 47° 36' 57" түүнээс зүүн урагш Хашаат сумын Эмээл толгой 102° 53' 18", 47° 33' 03" түүнээс зүүн урагш Баясгалан овоо (1658.3) 102° 55' 46", 47° 25' 21" түүнээс баруун урагш 102°50'00", 47°24'00" солбицол бүхий цэг, түүнээс урагш Лүн овоо (1447.6 тоот) 102° 49' 28", 47° 23' 03" түүнээс урагш 102°50'00", 47°22'00" солбицол бүхий цэг, түүнээс зүүн тийш 6 км-т орших 102°55'00", 47°22'00" солбицол бүхий цэг, түүнээс зүүн урагш 1428.4 тоот, 102° 57' 00", 47° 19' 33" түүнээс баруун урагш 1439.0 тоот 102° 54' 15", 47° 16' 13", түүнээс баруун урагш 1461.8 тоот 102° 48' 09", 47° 12' 19" түүнээс урагш Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын хилийн зааг болох Өлийн хөтөл (1527.0) 102° 48' 22", 47° 10' 38" түүнээс баруун тийш Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын хилийн дагуу Өлийн хошуу (1465.8) 102° 47' 02", 47° 10' 36" түүнээс баруун хойш Хангай овоо уул (1954.3) 102° 44' 38", 47° 11' 47" зэргийг дайран өнгөрч Их, Бага Арцатын голын уулзвар дахь 102° 43' 57", 47° 13' 20" солбицол бүхий цэг.

### ОРХОНЫ ХӨНДИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ



**Тэсийн голын сав орчмын байгалийн нөөц газрын хилийн зааг**

Монгол Улсын хойд хилийн 129 дүгээр багана (93°08'45", 50°35'53"), түүнээс зүүн тийш улсын хилийн дагуу 156 дугаар багана (94°21'10", 50°31'30"), түүнээс баруун тийш Таван улиасны төв 855.1 тоот (94°05'27", 50°30'57"), түүнээс баруун тийш 818.1 тоот (93°49'17", 50°29'34"), түүнээс баруун тийш 794.9.0 тоот (93°32'34", 50°29'35"), түүнээс баруун урагш Хар үзүүрийн төв 774.8 тоот (93°21'51", 50°27'05"), түүнээс баруун урагш 772.4 тоот (93°16'36", 50°24'57"), баруун хойш дархан цаазат газрын хилийн дагуу 768.7 тоот (93°12'15", 50°25'13"), 764.0 тоот (93°10'30", 50°26'57"), 767.7 тоот (93°13'17", 50°29'42"), 762.9 тоот (93°11'54", 50°31'41"), 763.7 тоот (93°08'57", 50°34'04"), түүнээс хойш Монгол Улсын хойд хилийн 129 дүгээр багана (93°08'45", 50°35'53").



**Даян Дээрхийн орчмын байгалийн дурсгалт газрын хилийн зааг**

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутагт орших Даян Дээрхийн агуй орчмын хамгийн баруун цэг болох Суварга уул 1616.2 тоот /101° 52' 42", 50° 33' 36"/, түүнээс зүүн хойш Сумангийн өндөр 1702.0 / 101° 57' 13", 50° 37' 4"/, түүнээс зүүн хойш Хайрхан даваа 1385.0 тоот / 102° 2' 32", 50° 40' 41" /, түүнээс зүүн тийш 1971.0 тоот / 102° 7' 39", 50° 40' 11" /, түүнээс зүүн урагш /1976.0 / 102° 8' 42", 50° 39' 36" тоот өндөрлөг, түүнээс зүүн урагш /1976.0/ 102° 11' 30", 50° 39' 8"/, 1904.0 / 102° 12' 45", 50° 37' 57" / тоот өндөрлөгүүдийг дайруулан Улсын хил дээрх Нашит овоо 1972.1 тоот /102° 16' 19", 50° 35' 57"/, түүнээс баруун урагш Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын хилийн заагийг даган 1895.5 тоот / 102° 12' 30", 50° 35' 51"/, Дүмбэн уул 1991.2 / 102° 8' 31", 50° 34' 50" / , 1965.0/ 102° 7' 41", 50° 33' 36", Тэвхэр асга /1973.8/ 102° 4' 15", 50° 31' 50" тоот өндөрлөгүүдийг дайран 1885.4 тоот /102° 2' 3", 50° 29' 59" /, түүнээс баруун хойш орших /101°.53'.00"/, 50°.26'.50"/ солбицол бүхий цэг, түүнээс баруун тийш /101°.50'.20", 50°.26'.50"/ солбицол бүхий цэг, түүнээс баруун урагш Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын хилийн заагт орших 1808.9 тоот /101° 57' 13", 50° 28' 43" /, түүнээс баруун тийш мөн сумдын хилийн заагийг даган Малхын булгийн эхийг дайран баруун урд зүгт орших 1499.2 тоот / 101° 52' 17", 50° 28' 27" /, түүнээс чанх хойшоо Суварга уул 1616.2 тоот өндөрлөг / 101° 52' 42", 50° 33' 36"



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот

**Ж.Батмөнх агсны ар гэрийн ахуй хангамжийн тухай Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ж.Батмөнх агсны ар гэрийн ахуй хангамжийн тухай Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Монгол Улсын төрийн тэргүүн агсан Ж.Батмөнхийн эхнэр Авирмэдийн Дариймаад дараахь тэтгэмж, тусламж олгохоор тогтоосугай:

1/ахуй хангамжид нь зориулж өөрийнх нь амьдарч байгаа орон сууцны хөлс /халаалт, ус, СӨХ, кабель гм/, цахилгааны болон гэрийн утасны нийт төлбөрийг төрөөс олгох;

2/сар тутам сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгох;

3/ биеийн эрүүл мэндийн байдлыг нь харгалзан үзэж 5 сая /таван сая/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгох."

2. Энэ тогтоолыг 2006 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/ 03 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3 дахь хэсэгт "Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана", 396.4 дэх хэсэгт "Бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 2/03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 29 | Улаанбаатар хот

**Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.7, 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн С.Оюуныг өөрийнх нь саналыг харгалзан Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 30 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/ 04 дүгээр дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсгийн "Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй" гэснийг, Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь хэсгийн "Барьцаалагч нь банк, эсхүл банк бус

санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэснийг; 174.3 дахь хэсгийн "Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 2/04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр** **Дугаар 31** **Улаанбаатар хот**

### Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Батаагийн Баттулга, Батчулууны Баярсайхан, Пандийн Бямбацэрэн, Мондооны Мэндбилэг, Жамбалсүрэнгийн Нарантуяа, Хандсүрэнгийн Пүрэвсүрэн, Данзангийн Сандаг-Очир, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Дашзэвэгийн Эрдэнэчулуун нарыг тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр** **Дугаар 32** **Улаанбаатар хот**

### Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Ж.Ядамсүрэнг Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас, Ж.Сүхбаатарыг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас, Р.Бурмаа, П.Бямбацэрэн, Г.Маналжав, Ж.Нарантуяа, Б.Очирбат, Д.Сандаг-Очир, Л.Хангай, Ч.Хүрэлбаатар, Д.Эрдэнэчулуун нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр** **Дугаар 33** **Улаанбаатар хот**

### Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Батаагийн Баттулга, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Батчулууны Баярсайхан нарыг тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

### Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоож, 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 34 дүгээр тогтоолын хавсралт*

### ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаалын зэрэг, дэв | Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | ТӨ-I | 355290 |
| 2 | ТӨ-II | 267800 |
| 3 | ТӨ-III | 206180 |
| 4 | ТӨ-IY, ТӨ-IY A | 197730 |
| 5 | ТӨ-Y, ТӨ-Y A | 183170 |
| 6 | ТӨ-YI, ТӨ-YI A | 174720 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

### Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүний туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 114660 төгрөгөөр, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 75010 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

### Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоож, 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

### МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаал | Албан тушаалын сарын цалин (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч | 176280 |
| 2 | Нийслэлийн шүүхийн шүүгч | 161980 |
| 3 | Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч | 169130 |
| 4 | Аймгийн шүүхийн шүүгч | 156780 |
| 5 | Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч | 158730 |
| 6 | Дүүргийн шүүхийн шүүгч | 151450 |
| 7 | Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч | 158730 |
| 8 | Сум, сум дундын шүүхийн шүүгч | 151450 |

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

### МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Албан тушаал | Албан тушаалын сарын цалин (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор | 174070 |
| 2 | Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор | 160160 |
| 3 | Нийслэлийн прокурор | 173290 |
| 4 | Нийслэлийн прокурорын орлогч | 161070 |
| 5 | Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор | 149370 |
| 6 | Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор | 146770 |

| | | |
|---|---|---|
| 7 | Аймаг, тээврийн прокурор | 166270 |
| 8 | Аймаг, тээврийн прокурорын орлогч | 154310 |
| 9 | Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор | 149370 |
| 10 | Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор | 146770 |
| 11 | Дүүргийн прокурор | 152360 |
| 12 | Дүүргийн прокурорын орлогч | 149370 |
| 13 | Дүүргийн прокурорын газрын туслах прокурор | 146770 |
| 14 | Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор | 145340 |
| 15 | Сум, сум дундын ахлах прокурор | 152360 |
| 16 | Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор | 145340 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр** | **Дугаар 37** | **Улаанбаатар хот**

### Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдийн авч байгаа нөхөн олговрын доод хэмжээг сард 40000 төгрөгөөр тогтоосугай.

2.Энэ тогтоолыг 2006 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2004 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 5 дугаар сарын 4-ний өдөр** | **Дугаар 38** | **Улаанбаатар хот**

### Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.7, 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаярын өөрийнх нь саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төсвийн байнгын хорооны гишүүнээр батлалсугай.

2.Энэ тогтоолыг 2006 оны 5 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 5 дугаар сарын 4-ний өдөр** | **Дугаар 39** | **Улаанбаатар хот**

### Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай

Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цэрэнхүүгийн Шаравдоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Шуудангийн үйлчилгээний авто машины парк шинэчлэлтийг үргэлжлүүлж, бүртгэл, хяналтын системийг нэвтрүүлж эхэлнэ. | 2005 | Ц.Цэнгэл |
| 213 | 3.7.14 | Үндэсний соёл, түүх, нүүдэлчдийн амьдралын хэв маягийг тусгасан, жуулчдыг олноор татах төслүүдийг идэвхтэй дэмжинэ. | 1. Үндэсний аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Үүнд:<br>- Улаанбаатар хотод жуулчны мэдээллийн төв байгуулна.<br>- Улаанбаатар-Хархорин чиглэлийн замын дагуу жуулчдад зориулсан түр буудаллах үйлчилгээний цэгүүдийг нэмэгдүүлнэ.<br>2. Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна. | 2005-2007<br>2005-2008 | Ц.Цэнгэл<br>Ж.Наранцацралт Ц.Цэнгэл |
| 214 | 3.7.15 | Олон улсын түвшинд нийцсэн аялал жуулчлалын цогцолборууд бий болгохыг хохиулэн дэмжинэ. Эдгээр цогцолборт зайлшгүй шаардлагатай үйлчилгээний төрөл зүйлийг нэвтрүүлэх, дэд бүтцийн барилга байгууламжийг барих, тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажилд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулна. | 1. Аялал жуулчлалын гол бүс нутагт аялал жуулчлалын жишиг цогцолборууд байгуулах ажлыг дэмжинэ.<br>2. Аялал жуулчлалын маршрутын дагуух замын трасс тогтоож тэмдэгжүүлнэ.<br>3. Жуулчны үйлчилгээний газруудын байршил тогтоох систем /GPS/-ийг нэвтрүүлнэ.<br>4. Бээжин-Улаанбаатар чиглэлд авто, мото уралдаан ралли зохион байгуулна.<br>5. Гадаад дотоодын жуулчдад зориулсан авто замын цахим атлас бэлтгэж, үйлчилгээнд нэвтрүүлнэ. | 2005-2008<br>2005-2007<br>2005-2008<br>2006-2007<br>2005-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |
| 215 | 3.7.16 | Жуулчин хүлээн авах байр, жуулчны бааз, жуулчдад зориулсан үйлчилгээнд тодорхой стандарт гаргаж мөрдүүлнэ. | 1. Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг боловсронгуй болгоно. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| 216 | 3.7.17 | Аймаг, хот, төвлөрсөн газруудыг аялал жуулчлал хөгжүүлэх тусгай хөтөлбөр, төлөвлөгөө, бүтэцтэй болгоно. | 1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулна.<br>2. Орон нутаг дахь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн захиргааны нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно. | 2005-2006<br>2006-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 217 | 3.7.18 | Аялал, жуулчлалын бүс нутгийн зам, гүүрийг тавих, тэмдэгжүүлэх ажлыг хийнэ. | 1. Хархорин - Хөшөө Цайдамын чиглэлд 46 км зам барина.<br>2. Хархорин орчмын болон Хөвсгөл, Өмнөговь дахь аялал жуулчлалын бүсийн авто замыг засч сайжруулж, тэмдэгжүүлнэ. | 2005-2007<br>2006-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |
| 218 | 3.7.19 | Жуулчдыг хүлээн авах зочид буудлуудын зэрэглэлийг дээшлүүлж, хүчин чадлыг эрс нэмэгдүүлнэ. | 1. Гурваас дээш одтой зочид буудлын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна.<br>2. Жуулчдыг хүлээж авах, зочид буудал, жуулчны баазын чанарыг сайжруулах талаар сургалт семинар зохион байгуулна. | 2005-2008<br>2005-2008 | Ц.Цэнгэл Нийслэлийн Засаг дарга<br>Ц.Цэнгэл |
| 219 | 3.7.20 | Дотоодын жуулчлалыг идэвхтэй хөгжүүлж, салбарын үйл ажиллагааны улирлын шинж чанарыг багасгана. | 1. Жуулчдыг зохион байгуулалттайгаар орон нутагт аялуулах хөтөлбөр боловсруулна. | 2006-2008 | Ц.Цэнгэл Аймаг, нийслэлийн Засаг дарга |

(*Үргэлжлэл. Түрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 17, 18 дугаарт нийтлэгдсэн.)

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Цаныг бааз, өвлийн улиралд ажиллах жуулчны бааз шинээр байгуулна. | 2006-2008 | Ц.Цэнгэл Нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Өвлийн улиралд зохион байгуулагддаг уламжлалт арга хэмжээнүүдийг зохион байгуулахад туслалцаа үзүүлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 4. Хархорин-Хужирт-Найман нуур бүс нутагт гадаад, дотоодын жуулчлалыг хөгжүүлэх шинэ маршрутын замыг засварлан, тэмдэгжүүлэх ажлыг хийнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| 220 | 3.7.21 | Жуулчдыг татах зорилгоор визийн хялбарчилсан системийг нэвтрүүлэх асуудлыг холбогдох орнуудтай хамтран судалж хэрэгжүүлнэ. | 1. Аялал жуулчлалын зах зээлийн орнуудын жуулчдад визийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл Н.Энхболд |
| 221 | 3.7.22 | Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг Монгол түмний түүх, уламжлалыг сэргээх, аялал жуулчлалын орчин, дэд бүтцийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан зохион байгуулна. | 1. Монгол орныг дэлхийн аялал жуулчлалын сонирхолтой бүс нутаг болгон хөгжүүлэхэд чиглэсэн гадаад сурталчилгааг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| | | | 2. Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх маршрутын дагуух зам, гүүрийг засах, тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| 222 | 3.7.23 | Улиастай-Улаангом-Мөрөн чиглэлийн тоон сүлжээг байгуулна. | 1. Хот хоорондын сүлжээний найдвартай ажиллагааг хангахын тулд STM-1 буюу түүнээс дээш хурдны шилэн кабелийн сүлжээ байгуулж эхэлнэ. | 2005 оноос | С.Батболд |
| 223 | 3.7.24 | Улаанбаатар-Дашинчилэн-Булган, Дашинчилэн-Арвайхээр чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчилж, Налайх-Багануурын дамжуулах сүлжээг өргөтгөнө. | 1. Улаанбаатар-Дашинчилэн чиглэлийн шилэн кабелийн сүлжээг дуусгах, цаашид өндөр хурдны дамжуулах байгууламжийн судалгааны ажлыг хийж, хамгийн оновчтой хувилбарыг сонгон хэрэгжүүлж эхэлнэ. | 2005 | С.Батболд |
| | | | 2. Налайх-Багануур чиглэлийн дамжуулах сүлжээг өргөтгөнө. | 2005 оноос | С.Батболд |
| 224 | 3.7.25 | Хотын захын гэр хороолол, дагуул хотуудыг холбоожуулж, интернэтийн сүлжээг өргөтгөнө. | 1. Малчид, хөдөөгийн хөдөлмөрчдөд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2007 оноос | С.Батболд |
| **3.8. Экспортын өрөөсгөл бүтцийг өөрчлөхөд чиглэсэн гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 225 | 3.8.1 | Экспортыг бүх талаар дэмжиж, түүнд эзэлж байгаа ашигт малтмалын хэмжээг бууруулахгүйгээр экспортын төрөлжилтийг нэмэгдүүлнэ. Экспортод гаргах шинэ бүтээгдэхүүнийг дэмжинэ. | 1. Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн хүрээнд Монголын ноолуур, ноолууран бүтээгдэхүүнийг газар зүйн заалттай болгох талаар судалгаа хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Экспортод гаргаж болох шинэ бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулах, гадаад зах зээлийн мэдээллээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Экспортыг дэмжих төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. Гадаадын зах зээлд бэлтгэсэн арьс ширний 70 хувийг борлуулснаар, хонины мах, консерв, архи, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг судалж, экспортлогчдод дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. Төрийн өмчид түшиглэсэн экспортын чиглэлийн үйлдвэрлэл, худалдааг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, зээлийн баталгаа, хөрөнгийн эх үүсвэрийг олохтой холбогдсон эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Гадаад орнуудын экспорт, хөрөнгө оруулалтын даатгал, зээлийн байгууллагуудын үйлчилгээнд Монгол Улсыг хамруулна.<br>6. Үндэсний үйлдвэрлэгч, экспортлогчид олон улсын хөрөнгийн болон металлын бирж дээр үйл ажиллагаа явуулах боломжийг судална.<br>7. Тавантолгой, Багануур, Шивээ овоо, Нарийнсухайт, Элдэв, Улаан-Овоо зэрэг нүүрсний уурхайнуудаас жилд 1.5 сая тонноос доошгүй нүүрс экспортлох санаачилгыг дэмжинэ.<br>8. Экспортод гаргах шинэ бүтээгдэхүүнийг дэмжих технологийн хөгжлийн сан байгуулах журам гаргаж хөрөнгийн эх үүсвэрийг бий болгоно.<br>9. Экспортын зориулалттай ашигт малтмал болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулалтын түвшинг дээшлүүлэхийг бодлогоор дэмжинэ. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Б.Эрдэнэбат<br>Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан<br>Д.Тэрбишдагва<br>Б.Эрдэнэбат |
| 226 | 3.8.2 | Гадаад орнуудтай хөдөлмөрийн зах зээлийг либералчлах, татварын хувь болон гүйлгээний зардлыг бууруулах, худалдааны хориг, саадуудыг багасгах талаар идэвхтэй ажиллана. | 1. Худалдааны гол түнш орнуудтай худалдааны хориг саадуудыг багасгах талаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийх арга хэмжээ авна.<br>2. Гадаадад суугаа худалдаа, эдийн засгийн ажилтнуудын техник, технологи, зах зээлийн талаар судалгаа хийх, Монголын бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахад чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор орон тоог нэмэгдүүлнэ. | 2005-2008<br>2006-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд<br>Б.Жаргалсайхан |
| 227 | 3.8.3 | Гадаад худалдаанд тулгарч байгаа тарифын болон тарифын бус саад, бэрхшээлийг хөнгөвчлөх талаар хоёр талт болон олон талт хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. | 1. Худалдааг хөнгөвчлөх асуудлаарх олон талт хэлэлцээнд өөрийн улсын ашиг сонирхлыг хамгаалан оролцоно. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 228 | 3.8.4 | Хоёр талын харилцаа худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, тэдгээртэй харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны томоохон түнш тухайлбал ОХУ, БНХАУ, АНУ, Европын холбоо, Япон зэрэг орнуудтай худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Н.Баяртсайхан |
| 229 | 3.8.5 | Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнчлэлийн болон одоогийн мөрдөж буй худалдааны гэрээ, хэлэлцээрүүдийн давуу талыг бүрэн ашиглана. | 1. Дэлхийн худалдааны байгууллагын болон олон талт худалдааны хэлэлцээрүүдийн давуу талуудыг ашигласнаас гарсан үр дүнгийн талаар судалгаа, шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.<br>2. Далайд гарцгүй хөгжиж байгаа орны хувьд хүндрэл бэрхшээлийг хөнгөвчлөх асуудлаар Дэлхийн худалдааны байгууллага болон олон улсын бусад байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.<br>3. Бангкокийн хэлэлцээр болон бүс нутгийн худалдаа, эдийн засгийн бусад гэрээ, хэлэлцээрт нэгдэх асуудлыг судалж, санал боловсруулна.<br>4. Дэлхийн худалдааны байгууллагын Засгийн газрын худалдан авах ажиллагааны хэлэлцээрт нэгдэх асуудлыг судалж шаардлагатай арга хэмжээг идэвхжүүлнэ. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2007<br>2006-2008 | Б.Жаргалсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан |
| 230 | 3.8.6 | ОХУ, Украин, Казахстан улсуудтай худалдааны гэрээ байгуулах талаар идэвхтэй хэлцэл хийж, ОХУ, БНХАУ, АНУ | 1. ОХУ, БНСУ, АНУ, Япон, Европын Холбоо болон бусад орнуудтай чөлөөт худалдааны гэрээ байгуулах асуудлаар холбогдох ажлын | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зэрэг орнуудтай чөлөөт худалдааны гэрээ байгуулах чиглэлээр ажиллана. | хэсэг байгуулж ажиллуулна. | | |
| 231 | 3.8.7 | Нэхмэл эдлэлийн бүтээгдэхүүнийг экспортлох онцгой эрх дуусгавар болж байгаатай холбогдуулан энэ бүтээгдэхүүний гадаад зах зээл дээрх Монгол Улсын байр суурийг хадгалахын тулд шинээр худалдааны таатай нөхцөлийг ашиглах арга хэмжээ авна. | 1. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, шинэ зах зээл олох, гадаад худалдааны таатай нөхцөл бүрдүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 232 | 3.8.8 | Хивс, хивсэнцэр, эсгий бүтээгдэхүүнд таатай нөхцөл олгох, шинэ зах зээлийг идэвхтэй хайна. | 1. Олс, хөвөн утасны гаалийн импортын татварыг тэглэх, хивс, хивсэнцэр, эсгий, нэхий, арьс ширэн бүтээгдэхүүнүүдийн импортын татварыг нэмэгдүүлэх чиглэлээр Импортын татварын хувь, хэмжээ тогтоох тухай УИХ-ын 1999 оны 27, 2000 оны 51 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. ОХУ, БНХАУ-аас манай улсын хивс, хивсэнцэр, эсгий бүтээгдэхүүнд ногдуулдаг импортын татварыг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг эрчимжүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 3. АНУ, Канад, Европын холбооны орнуудад манай улсын хивс, хивсэнцэр, эсгий бүтээгдэхүүнийг сурталчилах ажиллагаар идэвхжүүлж, худалдаанд электрон сүлжээ ашиглах боломжийг бүрдүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 4. Түүхий эд бэлтгэлийн тухай хуулийн төсөл боловсруулж батлуулан, хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 5. Түүхий эдийн боловсруулалтын төвшингээс хамааруулан экспортын татвар ногдуулах чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 233 | 3.8.9 | Зүүн, Зүүн өмнөд болон Зүүн хойд Ази, Европын орнуудтай бизнесийн харилцааг хөгжүүлэхэд анхаарч, Монгол Улсын эрх зүйн орчин, Монголын компани, монгол брэндүүдийг сурталчлах зорилгоор цахим-бизнес форум ажиллуулна. | 1. Цахим бизнес форум байгуулах асуудлаар төсөл боловсруулж, гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Зүүн хойд Ази, АСЕАН, АПЕК-ийн орнууд, Төв азийн орнууд болон худалдаа эдийн засгийн томоохон түнш орнуудтай худалдааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих талаар ажиллаж, бизнес уулзалтуудыг зохион байгуулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |
| 234 | 3.8.10 | Бүтээгдэхүүний стандартыг сайжруулснаар ОХУ, БНХАУ болон бусад зах зээлтэй худалдааны хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу Монгол Улсын стандартыг бүрэн хүлээн зөвшөөрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. | 1. Үндэсний стандартын түвшинг дээшлүүлэх, олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилт стандартыг авч хэрэглэх, бүтээгдэхүүний чанар, стандартын талаар байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>М.Энхсайхан<br>Сайд нар |
| | | | 2. Бүтээгдэхүүний чанар, стандартын талаар байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| 235 | 3.8.11 | Хөнгөлөлтийн ерөнхий зарчимд бараа, бүтээгдэхүүн нэмж оруулах талаар Европын Холбоо, АНУ, Япон болон бусад оронтой хийх хэлцлийг идэвхжүүлнэ. | 1. Европын холбоо, АНУ, Япон болон бусад худалдааны гол түншүүдтэй Хөнгөлөлтийн ерөнхий системд Монголын барааг нэмж хамруулах, худалдааг хөнгөвчлөх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |

## Дөрөв. ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4.1. Түүх, соёл, байгаль орчин, эдийн засгийн онцлогийг харгалзан хот төлөвлөлт, байгуулалт, барилга, газар зохион байгуулалтад шинэтгэл хийж, оршин суугчдынх нь эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 236 | 4.1.1 | Хот төлөвлөлтийн аргачлал, стандартыг олон улсын түвшинд хүргэж хот байгуулалтын тогтолцоог шинэчлэх ажлыг эхлүүлнэ. | 1. Канад, Солонгос, ОХУ, Герман, Япон зэрэг орнуудын хот байгуулалтын асуудлыг судалж, холбогдох баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, Хот байгуулалтын тухай хуульд зохих өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна. | 2005-2007 | Ж.Наранцацралт |
| | | | 2. Тогтвортой хотын үзэл баримтлалын хүрээнд гадаад орнуудын туршлагыг судлан хэрэгжүүлж, дүүрэг,хорооллын шинэ төвүүдийг байгуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2007 | Ж.Наранцацралт |
| 237 | 4.1.2 | "Дөчин мянган орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. "Дөчин мянган орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль эрх зүй, санхүү, татвар, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, газрын харилцаа, хот байгуулалтын оновчтой бодлогыг тодорхойлон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт<br>Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Төрийн ажилтан, албан хаагчдын орон сууцны дэд хөтөлбөр боловсруулж төрийн төв байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт<br>Сайд нар |
| 238 | 4.1.3 | Эртний нийслэл Хархоринг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 1. Хархорин хотыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт<br>Н.Баяртсайхан |
| 239 | 4.1.4 | Хот, суурин газруудын авто зам, гудамж талбайн тохижилтод иргэдийн аюулгүй байдлыг хангах стандартыг тогтоож мөрдүүлнэ. | 1. Хот байгуулалт, барилгын норм, дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. | 2005-2007 | Ж.Наранцацралт |
| | | | 2. Хот, суурин газрын зам талбайн засвар, арчлалтын норм, дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. | 2005-2007 | Ц.Цэнгэл |
| | | | 3. Хотын замын төлөвлөлтийн норм, дүрмийг шинээр боловсруулан мөрдүүлнэ. | 2005-2007 | Ц.Цэнгэл |
| 240 | 4.1.5 | Хүн амын нягтрал, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний төвлөрөлд нийцүүлэн засаг захиргааны шинэчлэлийн болон хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлнэ. | 1. Улсын хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв-хотуудын зорилтот хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхүү хуваарилах арга хөшүүргийг судлан тогтоож, хэрэгжүүлж эхэлнэ. | 2006 оноос жил бүр | Н.Баяртсайхан<br>М.Энхсайхан<br>Б.Эрдэнэбат<br>Ц.Цэнгэл |
| | | | 2. Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн стратегитэй уялдуулан Бүсүүдийн эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл холбооны хангамжийн сүлжээг үргэлжлүүлэн байгуулах зорилт арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган, гадаад орны зээл тусламжаар дэмжин хэрэгжүүлнэ. | 2006 оноос жил бүр | Н.Баяртсайхан<br>М.Энхсайхан<br>Ж.Наранцацралт |
| | | | 3. Бүс нутгуудыг эдийн засгийн хувьд биез даах хөгжихийг төрөөс дэмжиж төсөв, хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг бүсүүдээр тооцож төлөвлөх эхлэлийг тавина. | 2007 оноос | М.Энхсайхан |
| 241 | 4.1.6 | Хот, суурингийн дулаан, цэвэр ба бохир ус, цахилгаан шугам сүлжээнд дэвшилтэт, хэмнэлттэй технологи нэвтрүүлж, сэргээгдэх эрчим хүчийг | 1. Хот, суурин газрын цахилгаан, дулааны шугам сүлжээнд дэвшилтэт, хэмнэлттэй технологи нэвтрүүлэн хэрэглээний өсөлтийн хангана. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 2. Сэргээгдэх эрчим хүч ашиглахыг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 3. Хот, суурин газруудын дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний техникийн түвшинд үнэлгээ өгч, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ. | 2005-2007 | Ж.Наранцацралт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ашиглах замаар өсөн нэмэгдэх хэрэгцээг хангана. | 4. Хэмнэлттэй технологи нэвтрүүлж, нэмэгдэх хэрэгцээг хангах асуудлыг орон нутгийн удирдлагын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулж хэрэгжүүлнэ. | 2005-2007 | Ж.Наранцацралт |
| 242 | 4.1.7 | Хотын доторх бүсчлэлийн нарийвчилсан хил хязгаарыг тогтоох журам гаргаж мөрддөг болгох ажлыг хэвшүүлэн барилга байшинд чанар, зориулалтын ангилал тогтоож, регистрийн дугаар олгоно. | 1. Хот суурин газрын төлөвлөлтийн өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, хотын доторх бүсчлэлийн хилийг нарийвчлан тогтоож мөрдүүлэн хот байгуулалтын цэгцтэй бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.<br>2. Хот суурингийн газрын кадастрын хүрээнд барилга байшинд чанар, зориулалтын ангилал тогтоож, регистрийн дугаар олгож хотын кадастрын ажлыг эхлүүлнэ. | 2005-2008<br>2005-2008 | Ж.Наранцацралт Нийслэлийн Засаг дарга<br>Ж.Наранцацралт Нийслэлийн Засаг дарга |
| 243 | 4.1.8 | Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, замын сүлжээг тойргийн горимд оруулж, гол урсгалуудыг нэг чиглэлтэй болгох арга хэмжээ авна. | 1. Улаанбаатар хотын авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний судалгааг хийж, авто замын хөдөлгөөний менежментийг сайжруулж зарим чиглэлийн замуудыг тойргийн горимд оруулж урсгалыг нэг чиглэлийн хөдөлгөөнтэй болгох техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлнэ.<br>2. Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатал, түгжрэлгүй байлгах хяналтын болон зохицуулалтын арга хэмжээ авна.<br>3. Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношлогооны төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлж хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна. | 2005-2008<br>2005-2006<br>2005 | Ц.Цэнгэл Ж.Наранцацралт<br>Ц.Цэнгэл Д.Одбаяр Нийслэлийн Засаг дарга<br>Ц.Цэнгэл Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 244 | 4.1.9 | Орон сууц барих ажлыг эрчимжүүлж, орон сууцны зориулалтаар ашиглаж болох барилгын стандартыг тогтооно. Орон сууцны барилгын гүйцэтгэгч, захиалагч, түрээслэгч нар сууцны барилгын чанар, материалын эрсдэл болон хэрэглээний онцлогийн талаар худалдан авагч, түрээслэгч, хэрэглэгчдэд үнэн, зөв мэдээлэл олгодог байх шаардлагыг нэвтрүүлнэ. | 1. Орон сууцны барилгын чанар, аюулгүй байдал, техникийн үнэлгээг хийх журам боловсруулна. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 245 | 4.1.10 | Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ. | 1. Түгээмэл тархацтай барилгын материалын шинэ нөөцийг илрүүлэхэд чиглэсэн геологи, хайгуулын ажлыг нэмэгдүүлнэ.<br>2. Барилгын салбарт зайлшгүй шаардлагатай, импортоор авдаг, гол нэрийн зарим материал бүтээгдэхүүнийг онцлох ач холбогдлоор нь зэрэглэн гааль болон НӨАТ-аас чөлөөлөх, хөнгөлөх, нэмэх зэрэг зохицуулалт хийх замаар барилгын материалын үндэсний үйлдвэрлэл, зах зээлийг дэмжих эрх зүйн орчинг бий болгоно.<br>3. Дулаан тусгаарлах болон дулаан хадгалах өндөр үзүүлэлттэй ханын материал, сантехникийн хуванцар хоолойн үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрийг бүсчлэн байгуулахад татвар, зээлийн бодлогоор төрөөс дэмжих асуудлыг боловсруулна.<br>4. Барилгын материалын бөөний худалдааны цэгүүдийг байгуулна. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Ж.Наранцацралт Н.Баяртсайхан<br>Ж.Наранцацралт Н.Баяртсайхан<br>Б.Жаргалсайхан Ж.Наранцацралт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Барилгын материалын чанарын удирдлагын тогтолцоог бий болгоно. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 246 | 4.1.11 | Барилгажихад шаардлагатай дэд бүтэц бүхий газар, талбайг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 1. "Дөчин мянган орон сууц хөтөлбөрийн хүрээнд шинээр барилгажих газруудын дэд бүтцийг бий болгоход хувийн хэвшил, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Ж.Наранцацралт |
| | | | 2. Барилгажихад шаардлагатай эрчим хүчний хангамжийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| 247 | 1.1.12 | Автомашины зогсоолын зориулалт бүхий талбай, тахир дутуу иргэдийн дэд бүтцийн байгууламжийн байрлал, тэдгээрт тавих шаардлагыг хот төлөвлөлтийн орчин үеийн стандартад нийцүүлэх арга хэмжээ авна. | 1. Томоохон хотуудын төв гудамж, гол замуудын дагуу тахир дутуу хүний зориулалтын зам, орц, гарц, дохиоллын дэд бүтцийг бий болгоно. | 2006-2008 | Ц.Цэнгэл Л.Одончимэд |
| | | | 2. Тахир дутуу хүн зорчих зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглосон нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх талаар судалгаа хийнэ. | 2006 оноос | Ц.Цэнгэл Л.Одончимэд |
| | | | 3. Хот байгуулалт, барилгын норм норматив-техникийн баримт бичигт тахир дутуу иргэдийн дэд бүтцийн байгууламжийн талаар барилгын зураг төсөвт тусгаж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт Л.Одончимэд |
| | | | 4. Газар олгохдоо тухайн барилгын зориулалт, хэмжээтэй нь уялдуулан авто машины зогсоолын эдэлбэр газар болон тахир дутуу иргэдийн дэд бүтцийн байгууламжийн байрлалыг тогтоож өгөх, хэрэгжилтийг нь хангуулах заавар, журмыг боловсруулан мөрдүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| | | | 5. Авто машины зогсоолын зориулалттай талбай, байгууламжийг байгуулах, ашиглахад мөрдөх олон улсын стандартад түлгүүрласан үндэсний стандарт бий болгоно. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| | | | 6. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборын төслийг боловсруулан зам барих зураг төсөлд тусгаж хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| 248 | 4.1.13 | Барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалт, газар өмчлөх, эзэмших ашиглах, үнэлэх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болгож, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг иргэд чирэгдэлгүй олж авах боломжийг бүрдүүлнэ. | 1. Газрын харилцаа, хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн санг бий болгож, нээлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 249 | 4.1.14 | Хотын захын хорооллын ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, хог хаягдал зайлуулах ажил үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх санаачилгыг өрнүүлж дэмжлэг үзүүлнэ. | 1. Хотын зах болон суурин газрын дулаан, цахилгаан хангамжийн асуудлыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх санаачилгыг дэмжинэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 2. Гэр хорооллын тодорхой хэсэгт цэвэр, бохир усны шугам хоолой барьж байгуулах, хог хаягдал зайлуулах үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх, тэднийг урамшуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2005-2007 | Ж.Наранцацралт |
| 250 | 4.1.15 | Хот, суурин газрын гэр хорооллын нийтийн аж ахуйн барилга, байгууламжид засвар, шинэтгэл, өргөтгөл хийнэ. | 1. Хот суурин газрын гэр хорооллын нийтийн аж ахуй үйлчилгээний цэгүүдийн өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт хийж зайлшгүй шинэчилж засварлах, өргөтгөх ажлыг нийтийн аж ахуйн үйлчилгээний стандартын шаардлагад нийцүүлэн хийх ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | Ж.Наранцацралт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 251 | 4.1.16 | 17 аймгийн 102 сумын төвийн ундны усыг цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулан хот, суурин газрын хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангана. | 1. Архангай, Булган, Завхан, Сэлэнгэ, Өвөрхангай, Хэнтий, Баянхонгор, Увс, Төв, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Дорноговь, Ховд, Өмнөговь аймгуудын нийт 102 сумын төвийн усанд шинжилгээ хийж дүгнэлт гарган, усыг цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн сонголт хийж, дэс дараалаллыг тогтоон, үе шаттайгаар улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ. | 2005-2007 | Ж.Наранцацралт |
| 252 | 4.1.17 | Гэр хорооллын айлуудыг цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | 1. Хандивлагч орнуудын тусламж, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран гэр хорооллын айлуудыг цэвэр бохир усны нэгдсэн болон хэсэгчилсэн системд холбох ажлыг эхлүүлнэ.<br>- Улаанбаатар хотод 13 мянган өрхийн<br>- Хөдөө орон нутагт 2 мянган өрхийн | 2005-2008 | Ж.Наранцацралт Н.Баяртсайхан |
| 253 | 4.1.18 | Улаанбаатар хотын захын ашиглагдаагүй газар талбай дээр амины орон сууцны шинэ хотхонууд байгуулна. | 1. Хандивлагч орнуудын тусламж, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран Улаанбаатар хотын захын ашиглагдаагүй газар дээр амины орон сууцны шинэ хотхон байгуулна. | 2005-2008 | Ж.Наранцацралт Н.Баяртсайхан Нийслэлийн Засаг дарга |
| **4.2 Хөдөөгийн дэд бүтэц, харилцаа холбоог бүс нутгийн хэмжээнд хөгжүүлж, орон нутгийн онцлог, давуу талыг дэмжих замаар зах зээлд өрсөлдөх чадварыг нь бэхжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 254 | 4.2.1 | Газар хувьчлалыг хөдөө орон нутагт зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, газар хувьчлалын эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг хөдөөгийн иргэдэд олгоно. Зах зээлд ойр, замын дагуух газрыг хувьчилна. | 1. Хөдөөгийн иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг эрхийн бичиг олгох замаар шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлөөр хангана.<br>2. Орон нутагт тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх ажлыг зохион байгуулна. | 2005-2008<br>2005-2008 | Ж.Наранцацралт<br>Ж.Наранцацралт Д.Тэрбишдагва |
| 255 | 4.2.2 | Хөдөөгийн газрын харилцааны шинэтгэлд онцгой анхаарч, газрын харилцааны үг зохицуулалтыг нэгдсэн удирдамжаар хангана. | 1. Аймаг, сумдын газрын албадын үйл ажиллагааг бэхжүүлэн нэгдсэн удирдамжаар хангана. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 256 | 4.2.3 | Бүсийн тулгуур төв, томоохон хот, суурин газрын ойролцоо байгуулсан мах, сүүний чиглэлийн төрөлжсөн аж ахуйд урт хугацаагаар газар эзэмшүүлэх, ашиглуулах чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. | 1. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа иргэдэд бэлчээр болон эдэлбэр газрыг урт хугацаагаар эзэмшүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | 2005 | Д.Тэрбишдагва Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 257 | 4.2.4 | Улсын төсвийн болон дотоод, гадаадын зээл тусламж, хандивын хөрөнгөөр 1900-гаас доошгүй худагт засвар шинэчлэлт хийж, 800-гаас доошгүй инженерийн хийцтэй худаг | 1. Жил бүр улсын төсвийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 350 - аас доошгүй худагт засвар хийж, 2005-2006 онуудад гадаадын төсөл хөтөлбөрөөр 660 худагт засвар шинэчлэлт хийнэ.<br>2. Жил бүр улсын төсвийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 200- аас доошгүй худаг шинээр гаргаж, бэлчээрийн ашиглалт, даацыг нэмэгдүүлэх. | 2005-2008<br>2005-2008 | Д.Тэрбишдагва Аймаг, нийслэлийн Засаг дарга<br>Д.Тэрбишдагва Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шинээр гаргах ажлыг говь, тал хээрийн бүсийн аймгуудад төвлөрүүлэн зохион байгуулж, иргэдийн оролцоотойгоор гар худаг нэмж гаргах ажлыг хөхиүлэн дэмжинэ. | 3. Алслагдсан бүс нутаг, ашиглалтгүй бэлчээрт усны хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх | 2005-2008 | Д.Тэрбишдагва<br>И.Эрдэнэбаатар |
| 258 | 4.2.5 | Бүсүүдийн эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:<br>4.2.5.1 Баруун бүсэд: Тайшир, Дөргөний усан цахилгаан станцуудыг барьж, Алтай-Тайшир-Улиастай, Дөргөн-Мянгадын 110 кв.вт-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамуудыг байгуулна.<br>4.2.5.2 Хангайн бүсэд: Арвайхээр-Баянхонгорын 110 квт-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, зарим сумдад бага оврын усан цахилгаан станцыг барина.<br>4.2.5.3 Төвийн бүсэд: Төв, Хангайн бүсэд 100 мвт-аас доошгүй хүчин чадалтай дулааны болон усан цахилгаан станц барих боломжийг судалж бэлтгэлийг хангана.<br>4.2.5.4 Зүүн бүсэд: Зүүн бүсийн эрчим хүчний системийг төвийн эрчим хүчний системд холбон, нэгдсэн сүлжээ үүсгэнэ. | 1. Тайшир, Дөргөний усан цахилгаан станцуудыг барьж ашиглалтанд оруулна.<br>2. Алтай-Тайширын 35 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг ашиглалтанд оруулна.<br>3. Тайшир-Улиастайн 110 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг ашиглалтанд оруулна.<br>4. Дөргөн-Мянгадын 110 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг ашиглалтанд оруулна.<br>5. Арвайхээр-Баянхонгорын 110 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг ашиглалтанд оруулна.<br>6. Завханы Тосонцэнгэл, Хөвсгөлийн Эрдэнэбулган сумдад бага оврын усан цахилгаан станц барина.<br>7. Шинэ эх үүсвэрийн судалгааг хийж, техник-эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааг боловсруулж бэлтгэлийг хангана.<br>8. Өндөрхаан-Баруун Уртын 110 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж төвийн эрчим хүчний системтэй холбон эрчим хүчний нэгдсэн сүлжээ үүсгэх нөхцөлийг бүрдүүлж эхэлнэ. | 2004-2007<br>2005<br>2004-2007<br>2005-2006<br>2004-2007<br>2004-2006<br>2004-2008<br>2005-2008 | Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат |
| 259 | 4.2.6 | Хөдөөгийн малчин айл өрхийг нар, салхины цахилгааны эх үүсвэрээр хангаж, "Буман нарны гэр", "100 мянган нарны гэрэл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. "Буман нарны гэр" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2004-2007 | Б.Эрдэнэбат<br>Н.Баяртсайхан |
| 260 | 4.2.7 | Салхины эрчим хүчний нөөцийг судалж бага, дунд хүчин чадалтай салхин парк байгуулах бэлтгэлийг хангана. | 1. Төв аймгийн Салхит ууланд салхин станц байгуулах талбайг сонгох нарийвчилсан хэмжилт судалгаа хийх, улмаар дунд хүчин чадлын салхин парк байгуулах санаачилгыг дэмжинэ.<br>2. Салхины эрчим хүчийг ашиглах салхины зохих нөөц бүхий бүс нутагт салхин парк байгуулах урьдчилсан судалгаа хийлгэнэ. | 2005-2008<br>2005-2008 | Б.Эрдэнэбат<br>Б.Эрдэнэбат |
| 261 | 4.2.8 | Иргэд, залуучуудад бизнес эрхлэхэд нь туслах зорилготой бизнес арилжаа, мэдээллийн төвүүдийг алслагдмал аймаг, хотуудад байгуулахыг дэмжинэ. | 1. Орон нутагт байгуулах "Жижиг, дунд үйлдвэрүүдэд зөвлөгөө өгөх алба"-ны дэргэд иргэд, залуучуудад бизнес эрхлэхэд нь туслах зорилготой бизнес арилжаа, мэдээллийн төвүүдийг байгуулах чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>С.Батболд |
| 262 | 4.2.9 | Архангай, Булган, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдийн нийтийн аж ахуйг | 1. Төслөөр хийгдэх барилга угсралтын ажлыг дуусгаж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөгжүүлэх 2 дугаар ээлжийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2. Тодорхой гэр хорооллын айлуудыг цэвэр, бохир усны шугамтай холбоно. | 2005-2008 | Ж.Наранцацралт |
| 263 | 4.2.10 | Төвлөрсөн цахилгаан хангамжийн эх үүсвэрт 40-өөс доошгүй сумын төвийг холбоно. 10-аас доошгүй сум, суурин газруудад нар, салхи, дизелиэр хосолсон парк бий болгоно. | 1. Төвлөрсөн цахилгаан хангамжийн эх үүсвэрт сумдын төвийг холбох ажлыг үргэлжүүлж 40-өөс доошгүй сумын төвийг нэмж холбоно. | 2005-2008 | Б.Эрдэнэбат Н.Баяртсайхан |
| | | | 2. 10-аас доошгүй сум суурин газруудад ус, нар, салхи, дизель хосолсон станц бий болгоно. | 2005-2008 | Б.Эрдэнэбат Н.Баяртсайхан |
| | | | 3. Баруун бүсийн эрчим хүчний системийг сайжруулах цогц арга хэмжээ авна. | 2006-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 4. Дархан, Эрдэнэтийн ДЦС-уудын зуухны шинэчлэлтийн асуудлыг шийдвэрлэнэ. | 2006-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 5. Эрчим хүчний найдвартай ажиллагаа, хүчдэлийн тогтворжилтыг хангах зорилгоор Өвөрхангайн Баянтээг, Увсын Хартарвагатайн нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станц барих асуудлыг эхлүүлнэ. | 2006-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 6. Алслагдсан сум, суурин газрыг цахилгаан эрчим хүчээр хангах хүрээнд Хөвсгөлийн Чаргайтын УЦС барих асуудлыг эхлүүлнэ. | 2006-2008 | Б.Эрдэнэбат |
| 264 | 4.2.11 | Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Мөст, Увс аймгийн Баруунтуруун, Хэнтий аймгийн Батширээт, Завхан аймгийн Тосонцэнгэл, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумдад бага өөрийн усан цахилгаан станц барьж, Орхон эсвэл Эгийн гол дээр 100 мвт-аас доошгүй хүчин чадалтай усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ. | 1. Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Мөст, Увс аймгийн Баруунтуруун, Хэнтий аймгийн Батширээт, Завхан аймгийн Тосонцэнгэл, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумдад бага өөрийн усан цахилгаан станц барьж ашиглалтанд оруулна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат Н.Баяртсайхан |
| | | | 2. Эгийн голын болон Орхоны усан цахилгаан станцыг барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж эхлүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | Б.Эрдэнэбат Н.Баяртсайхан |
| **4.3 Хот, хөдөөг холбосон зам гүүр, харилцаа холбооны нөхцөлийг сайжруулж, хөдөөний алслагдмал байдлыг багасгана. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 265 | 4.3.1 | Тээврийн салбарын хөгжлийн стратегийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Бүх төрлийн тээврийн салбарын хөгжлийн суурь судалгаа гарган Үндэсний тээврийн стратеги боловсруулна. | 2005 | Ц.Цэнгэл |
| | | | 2. Тээврийн стратегийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулж эхний ээлжийн төслүүдийг хэрэгжүүлж эхэлнэ. | 2006-2008 | Ц.Цэнгэл |
| 266 | 4.3.2 | Орон нутагт агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлнэ. | 1. Орон нутгийн нислэгийн шугамыг хуваарилах, агаарын тээвэрлэлтийн эрх олгох, тээврийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр эдийн засаг, эрх зүйн орчныг боловсронгуй болгож шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| 267 | 4.3.3 | Орон нутгийн нисэх буудлуудыг орчин үеийн, ашиглалтын өртөг багатай, бага өөрийн онгоц хүлээн авах стандарт, шаардлагад нийцүүлж тоноглоно. | 1. Даланзадгад хотод хатуу хучилттай аэродром бүхий нисэх буудал барьж дуусгана. | 2005-2007 | Ц.Цэнгэл |
| | | | 2. Орон нутгийн дөрвөөс доошгүй нисэх буудлуудад онгоц хөөрч, буух зурвасыг засч сайжруулах арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| 268 | 4.3.4 | Орон нутгийн нислэгийн зориулалт бүхий онгоцны паркийг шинэчлэхэд | 1. Монгол Улсад шинээр оруулж ирэх агаарын хөлөг, түүний сэлбэг, материалд гаалийн болон бусад татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох асуудал боловсруулна. | 2005 | Ц.Цэнгэл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гадаадын болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ | 2. Агаарын хөлөг түрээсээр ашиглахад хөнгөлөлт эдлэх зорилгоор хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн олон улсын баталгаат эрхэд /ашиг сонирхлын/ хамаарах Кейптауны Конвенци болон Агаарын хөлөгт тусгайлан хамаарах Протоколд Монгол Улс нэгдэн орох арга хэмжээ авна. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| 269 | 4.3.5 | Мянганы зам барих ажлыг үргэлжлүүлж, түүний дагуух гүүр барих, даваа засах ажлыг эрчимжүүлнэ. | 1. Хэрлэнгийн гүүр- Мөрөн сум чиглэлийн 165 км авто замыг барьж ашиглалтад оруулна.<br>2. Хашаат, Бураатын давааны зам барих ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.<br>3. Өлгий-Цагаан нуурын 30 км авто замыг ашиглалтад оруулна.<br>4. Дашинчилэн-Яруу чиглэлийн авто замыг үргэлжлүүлэн барина. | 2005<br>2005-2007<br>2006<br>2005-2008<br>2005-2007 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |
| 270 | 4.3.6 | Авто замын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 1. Авто зам ашигласны төлбөр авах журмыг боловсронгуй болгоно. | | |
| 271 | 4.3.7 | Авто зам, гүүр барих, засварлахад хөрөнгө оруулалт хийхийг хөхиүлэн дэмжинэ. | 1. Засвар арчлалтын ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж зам засварын компаниудыг зөвхөн засвар, арчлалтын ажлыг дагнан гүйцэтгэдэг тогтолцоонд шилжүүлнэ.<br>2. Өндөр хүчин чадлын уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрийн бааз, талбай хүртэлх замыг өөрсдийнх нь хөрөнгөөр засвар, арчилалтын ажлыг хийлгэх арга хэмжээ авна. | 2005-2008<br>2005-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |
| 272 | 4.3.8 | Ховд–Улаангом–Хандгайт, Булган–Ярант, Эрдэнэт–Булган–Үнэт, Чойр–Сайншанд– Замын-Үүд, Хархорин–Цэцэрлэг–Тосонцэнгэлийн чиглэлийн хатуу хучилттай авто замуудыг барих буюу үргэлжлүүлэн барина. | 1. Улаангом-Хандгайт чиглэлийн 58 км авто зам, Булган-Ярантын 65 км авто замыг барьж ашиглалтад оруулна.<br>2. Эрдэнэт-Булган-Үнэт чиглэлийн 146 км хатуу хучилттай авто замыг Кувейтийн сангийн зээлийн хөрөнгөөр, Налайх-Чойр чиглэлийн 200 км хатуу хучилттай авто замыг Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулна.<br>3. Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замыг барина.<br>4. Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн хэсэгчилсэн замуудыг үргэлжлүүлэн барина.<br>5. Завханы Буянтын төмөр бетон гүүр, Увсын Тээлийн гүүрийг барьж ашиглалтад оруулна. | 2005-2006<br>2005-2006<br>2005-2006<br>2005-2009<br>2005-2006 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |
| 273 | 4.3.9 | Арвайхээр–Баянхонгор–Говь-Алтай–Ховд чиглэлийн авто замуудыг хэсэгчилсэн хайрган хучилттай замуудыг барьж ашиглалтад оруулна. | 1. Арвайхээр- Ховд чиглэлийн хэсэгчилсэн 93 км хайрган замыг үргэлжлүүлэн барьж дуусгана. | 2005 | Ц.Цэнгэл |
| 274 | 4.3.10 | Багануур-Өндөрхааны чиглэлийн хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн барьж, Ховдын Булган-Ховд, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн зам, гүүрийн ажлыг эхлүүлэх арга хэмжээ авна. | 1. Багануур-Өндөрхаан чиглэлийн авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулна.<br>2. Ховдын Булган - Ховд, Өндөрхаан - Сүмбэр чиглэлийн авто замын техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангана. | 2005-2008<br>2006-2008 | Ц.Цэнгэл<br>Ц.Цэнгэл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Хэрлэн голын төмөр бетон гүүр, болон Хуцаа, Хужирт, Цэнхэр, Мөрөнгийн голын гүүрүүдийг шинэчилнэ. | 2005-2009 | Ц.Цэнгэл |
| 275 | 4.3.11 | Улс хоорондын авто зам, төмөр зам, нисэх буудал барих талаар судалгаа хийх, холбогдох хэлэлцээр, хөрөнгө оруулалт татах ажлыг идэвхжүүлнэ. | 1. Олон улсын чанартай нисэх буудлыг шинээр байгуулах судалгаа хийж, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| | | | 2. Шинээр төмөр зам барих асуудлыг судалж холбогдох арга хэмжээ авна. | 2005-2006 | Ц.Цэнгэл |
| | | | 3. Азийн авто замын сүлжээтэй нэгдсэн гурван / А3, А4, А32 / чиглэлийн авто замыг барих, сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар авна. | 2005-2008 | Ц.Цэнгэл |
| 276 | 4.3.12 | Улаанбаатар-Эрдэнэсантын хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн шинэчлэнэ. | 1. Улаанбаатар –Эрдэнэсант чиглэлийн 176 км хатуу хучилттай замын шинэчлэлтийн техник-эдийн засгийн үндэслэлийг хийж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн ажлыг нь эхлүүлнэ. | 2005-2008 | Ц.Цэнгэл |

### Тав. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **5.1 Байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогын уялдааг сайжруулж, экологийн баримжаатай нийгэм, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ. Байгаль орчинтой холбоотой мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгож, байгаль хамгаалахад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 277 | 5.1.1 | Гадаад улс орнууд, олон улсын байгууллагаас авах тусламжийн хөрөнгийн тодорхой хэсгийг шар шороон нүүдэл, цөлжилттэй тэмцэх иж бүрэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах чиглэл баримтална. | 1. Гадаад орон, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэг, тусламжийн хүрээнд бүс нутгийн түвшинд шар шороон шуурга гарах эх үүсвэрийг тогтоох ажлыг газраас болон зайнаас тандан судлах, тухайн орчны хөрс, ургамлан бүрхэвчийг сэргээх, хамгаалах арга хэмжээг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Цөлжилт, газрын доройтолд нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлан тогтоож, тэдгээрээс сэргийлэх арга замыг тодорхойлон, цөлжилт, элсний нүүлтийн мониторингийн станц суурилуулах, зүүн хойд Азийн цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах сүлжээнд нэгдэн орох ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 278 | 5.1.2 | Ойжуулалт, усжуулалтын бодлогыг шинэ түвшинд гаргаж, ялангуяа нутаг орных ойжуулахад иргэдийн оролцоог үлэмж нэмэгдүүлнэ. | 1. Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх замаар ойг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Жилд 5-аас доошгүй тн мод сөөгний үр бэлтгэн, 20.0 сая ширхэгээс доошгүй тарьц суулгац ургуулж, 9000 га талбайд ойг нөхөн сэргээх ажил хийнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Говийн баян бүрдийн тооллого явуулж, экологийн дүгнэлт гарган, хамгаалах арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Гадаргын болон гүний усны нөөцийг зохистой ашиглах замаар мод үржүүлэх, ойжуулах ажил эрхэлж байгаа иргэдийн үйл ажиллагааг дэмжинэ. | 2005 -2008 | И.Эрдэнэбаатар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 279 | 5.1.3 | Ойг нөхөн сэргээх, түүний дагалт баялгийг бүрэн боловсруулж ашиглах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээ авна. | 1. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ойн нөөц түүний дагалт баялгийг зохистой ашиглах хууль эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Ойн дагалт баялгийн нөөцийг тогтоож, зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Ойн дагалт баялгийг бүрэн боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулахад гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсгэврийг татах, ажлын байр шинээр бий болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Иргэдийн хүнсний хангамжийг дээшлүүлэх зорилгоор ойн дагалт баялгийг ашиглах зөвлөмж, гарын авлага боловсруулах, зарим ургамлын плантаци байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Д.Тэрбишдагва |
| | | | 5. Ойгоос мод бэлтгэх, тээвэрлэх, ашиглах эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг ойгоос олгох модны дээд хэмжээтэй уялдуулж, хууль бус мод бэлтгэх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 280 | 5.1.4 | Мод, модон материал болон эх орны байгаль, экологийн нөхцөлд зохицон амьдрах чадвар бүхий тарьц, суулгацыг импортлох, үйлдвэрлэлийн зориулалттай модны хэрэглээг импортын модоор хангахад чиглэгдсэн санаачилгыг дэмжинэ. | 1. Мод, модон материал болон эх орны экологийн нөхцөлд зохицон амьдрах чадвар бүхий тарьц, суулгацыг импортлох үйл ажиллагааг дэмжих эдийн засаг, татварын механизм бүрдүүлнэ. | 2006-2008 | И.Эрдэнэбаатар<br>Н.Баяртсайхан |
| | | | 2. Мод, модон материалын импорт, экспортыг хянах, тоо чанарын бүртгэлийн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Мод, модон материал болон үйлдвэрлэлийн зориулалттай модны импортын татвар, НӨАТ-ыг тэглэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ж.Наранцацралт<br>И.Эрдэнэбаатар<br>Н.Баяртсайхан |
| 281 | 5.1.5 | Хөрс, ус, агаар зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулсны хариуцлагын эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, байгаль орчинд хоргүй, утаа багатай, хатуу, шингэн, хийн түлшний хэрэглээг өргөтгөхөд чиглэгдсэн аж ахуйн үйл ажиллагааг дэмжин, өргөжүүлнэ. | 1. Цэвэр үйлдвэрлэлийн механизмыг нэвтрүүлэх, Киото-ийн протоколийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Сайд нар |
| | | | 2. Төв, суурин газарт агаарын бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандарт тогтоож, агаар бохирдуулсны төлбөр, агаарын бохирдлыг бууруулсны урамшил олгох эрх зүйн үндэс, хяналт хариуцлагын механизм бий болгож мөрдөнө. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгаж, утаагүй хот болгох зорилгоор гэр хорооллын түлшний хэрэглээнээс нүүрсийг шахаж, хий, цахилгаан, шахмал түлшний хэрэглээнд аажмаар шилжих, гэр хорооллын айл өрхүүдийн өмчлөл, эзэмшлийн газраар барьцаалан нийтийн орон сууцаар хангах талаар хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Нийслэлийн<br>Засаг дарга |
| | | | 4. Улаанбаатар хотын утааг багасгах техник технологийн болон хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэнэ. | 2006-2008 | И.Эрдэнэбаатар<br>Б.Эрдэнэбат<br>Нийслэлийн Засаг дарга |
| | | | 5. Гэр хорооллын айл өрхийг сайжруулсан зуухаар шат дараатай хангах, бага, дунд чадлын нам даралтын зуухнуудад тавигдах экологийн шаардлагуудыг боловсруулж мөрдүүлнэ. | 2005-2006 | И.Эрдэнэбаатар |
| | | | 6. Утаа багатай шахмал хорголжин түлш, гал түргэн ноцоогчийг зохион бүтээх, үйлдвэрлэх замаар түлшний чанарыг сайжруулан шаталтаас гарах бохирдлыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2005-2007 | И.Эрдэнэбаатар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 7. Авто тээврийн хэрэгслийн экологийн үнэлгээний стандарт, техникийн шаардлагуудыг боловсруулан мөрдүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 8. Нийтийн тээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн хий ашиглах туршилт судалгаа хийнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 9. Утаагүй буюу утаа багатай шахмал түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлж шахмал түлшийг ахуйн хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 10. Хүрэн нүүрсийг утаагүйжүүлэх төсөл боловсруулж, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| | | | 11. Нүүрсний уурхайг түшиглэн нүүрсийг хийжүүлэх технологид тулгуурласан хийн генераторын цахилгаан станцыг барих асуудлыг судална. | 2005-2008 | Б.Эрдэнэбат |
| 282 | 5.1.6 | Байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх чадавхийг нэмэгдүүлнэ. | 1. Ус цаг уурын мэдээ боловсруулах, дамжуулах, цаг агаарын урьдчилсан болон урьдчилан сэргийлэх мэдээ гаргах техник хангамж, технологийг сайжруулж мэдээний тарцыг нэмэгдүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Радио, телевиз, интернет, холбоо зэрэг мэдээллийн сувгаар дамжуулах цаг уурын мэдээний давтамжийг нэмэгдүүлж, түгээлтийн арга хэлбэрийг сайжруулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Цацрагийн фон болон агаар, ус, хөрсөн дэх цацрагийн бохирдолт, тэдгээрийн болзошгүй өөрчлөлтийн тухай мэдээг хөрш орнуудтай байнга солилцож, энэ талаарх хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх, мэргэжлийн нэгж удирдлагын байгалийн гамшиг аюулын үед ажиллах чадавхи, дадлагыг сайжруулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар ОБ-ын сайд |
| | | | 5. Агаар мандлын үзэгдэл явцад зориуд нөлөөлөх аргаар ой, хээрийн түймрийг унтраах, хур тунадас нэмэгдүүлэх, таримал ургамлыг мөндрөөс хамгаалах арга хэмжээг захиалагчтай гэрээ хийх замаар хэрэгжүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 283 | 5.1.7 | Тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, удирдлагын чадавхийг бэхжүүлэх, материаллаг орчин нөхцөлийг сайжруулна. | 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Тусгай хамгаалалттай газар нутгийг Дэлхийн шим мандлын нөөц газар, байгаль соёлын өв, ус намгархаг газрын сүлжээнд хамруулах, хил дамнасан дархан газар байгуулах, хамгаалалтыг бэхжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг бэхжүүлэх, байгаль хамгаалагчдын мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, дүрэмт хувцас, унаа, техник хамгаалах хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 284 | 5.1.8 | Монгол Улсын нутаг дэвсгэрт буй ашигт чанар нь мэдэгдсэн, эмчилгээ болон хүнсний зориулалтаар хэрэглэгддэг эмийн ховор ургамал, ургамлын төрөл зүйлийг хамгаалахад анхаарч, таримал | 1. Ашигт ургамлын биологи экологийн судалгааг дэмжиж, ургамлын нөөцийн экологи эдийн засгийн үнэлгээг шинэчилэн боловсруулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Эм, хүнс, техникийн зориулалттай зарим ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах аргаар ашиглах үйл ажиллагааг дэмжинэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байдлаар уржүүлж орлого олох боломжийг иргэдэд олгоно. | 3. Хүнс болон тэжээлийн үнэт ургамлыг тарималжуулах нутагшуулах талаар шинжлэх ухааны төсөл захиалан хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| 285 | 5.1.9 | Байгалийн тэнцвэрт байдал, ой, бэлчээр, тариалангийн талбайг хамгаалахын тулд хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг технологийн горимын дагуу зохион байгуулна. | 1. Жилд дунджаар 500.0 мянган га талбайд ойн хөнөөлт шавж, өвчний судалгааг тоймчилсон болон нарийвчилсан хэлбэрээр хийж, тэмцэх ажлыг жилд 40.0 мянгаас доошгүй га талбайд гүйцэтгэнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Д.Тэрбишдагва |
| | | | 2. Монгол орны уур амьсгал, ойн хөнөөлт шавжийн биологи онцлогт тохирсон дэвшилтэт арга технологи, тэмцлийн ажилд хэрэглэх биобэлдмэлийг оновчтой сонгох ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 286 | 5.1.10 | Усны бодлогын шинэчлэлийг эрчимжүүлж гол, мөрний сав газрыг хамгаалах, хэрэглээг зохистой болгох, гадаргын ус ашиглалтыг нэмэгдүүлэх, гүний хайгуулын ажлыг өргөжүүлэх, томоохон усан сан байгуулах, бороо, цасны усыг ашиглах төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | 1. Усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж усны хэрэглээг нөөц, нөхөн сэргэх чадвартай нь уялдуулан зохицуулах менежментийг боловсронгуй болгоно. | 2006-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. "Туул-Тэрэлжийн усны нөөцийн цогцолбор" төсөл боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Эдийн засгийн бүсийн зарим тулгуур төвийн усан хангамжийн нэмэгдэл эх үүсвэрийн судалгаа явуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагчдын судалгаа гаргаж, усны нөөц нөхөн сэргэх чадварт тулгуурлан гэрээ байгуулан ажилладаг журамд шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 5. Монгол орны гадагш урсацгүй нууруудын усны чанар, бионөөцийн судалгааны ажлыг хийх, нуурын экологийн сургалт, сурталчилгаа явуулах лаборатори-сургалтын бааз байгуулна. | 2005-2007 | И.Эрдэнэбаатар |
| | | | 6. Усны үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор усны төлбөрийн эрх зүйн шинэчлэлийг хийнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 7. Гадаргын усны нөөц, усны эрчим хүчийг зохистой ашиглах үйл ажиллагааг дэмжих, усан цахилгаан станц, усны нөөцийн цогцолборуудын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргана. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 8. Усан сан, цөөрөм, хөв байгуулж, хадлан тариалангийн талбайг усжуулах зорилгоор боломжтой газруудад хайгуул, судалгаа явуулж байгаль орчны үнэлгээ хийлгэн зураг төсөл гаргуулахад нь иргэд, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008 | Д. Тэрбишдагва<br>И.Эрдэнэбаатар |
| 287 | 5.1.11 | Байгальд удаан задардаг, хорт хаягдлыг үлэмж хязгаарлаж, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжинэ. | 1. Удаан задардаг органик бохирдуулагчийн нэр, төрөл, хэмжээг тогтоох, хорт хаягдлын гаралтыг олон улсын стандартын хэмжээнд хүртэл бууруулах төлөвлөгөө боловсруулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Аюултай хог хаягдлын үндэсний ангиллыг олон улсын конвенцийн заалттай нийцүүлэн гаргах, аюултай, хортой бодис, бүтээгдэхүүний ангилал, хаяг шошгын тухай үндэсний стандарт боловсруулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг хянах, эргүүлж ашиглахтай холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулан мөрдүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Зарим томоохон хот суурин газрын хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 5. Хог хаягдлын дахин боловсруулах улсын хэмжээний сүлжээг байгуулах, хог хаягдал цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх асуудлаар туршилтын загвар төслүүд хэрэгжүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 288 | 5.1.12 | Бүх нийтэд экологийн боловсрол олгох, байгаль дэлхийгээ хамгаалж ирсэн үндэсний уламжлалыг өвлүүлэх ажлыг өргөн хүрээнд өрнүүлнэ. | 1. Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт экологийн боловсрол олгох асуудлыг шинэчлэн тусгах, байгаль хамгааллын чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ авна.<br>2. Байгаль орчныг хамгаалах ардын уламжлалт арга, ухаан, номлолыг байгаль орчны төрийн бодлоготой хослуулан олон нийтийн оролцоо, төрийн бус байгууллагын түншлэлийг сайжруулна.<br>3. Байгаль хамгаалах аян, сургалт зохион байгуулж, мэдээлэл сурталчилгаа явуулна. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | И.Эрдэнэбаатар Ө.Энхтүвшин<br>И.Эрдэнэбаатар Ө.Энхтүвшин<br>И.Эрдэнэбаатар |
| 289 | 5.1.13 | Хүрээлэн буй байгаль орчны төлөв байдлын тухай мэдээллийг орон нутгийн статистикийн мэдээлэлд оруулж хэвшүүлнэ. | 1. "Байгаль орчны төлөв байдлын тайлан"-г олон нийтэд хүргэх ажлыг сайжруулах арга хэмжээ авна.<br>2. Байгалийн нөөц баялгийн статистик мэдээллийн зарим үзүүлэлтэд өөрчлөлт оруулж мөрдүүлнэ. | 2005-2008<br>2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>И.Эрдэнэбаатар |
| 290 | 5.1.14 | Байгаль орчинг бохирдуулсны торгуулийг байгаль бохирдуулагчийн шууд эх үүсвэртэй холбон гаргуулах тогтолцоог нэвтрүүлнэ. | 1. Хөрс, агаар, усан орчныг бохирдуулагч хариуцлага хүлээдэг, төлбөр төлдөг эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно.<br>2. Байгаль орчин бохирдуулсан, байгалийн нөөц баялагт халдсан этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, эд хөрөнгийн нөхөн төлбөрийн хэмжээг учируулсан хохирлын хэмжээтэй уялдуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. | 2005-2008<br>2006-2008 | И.Эрдэнэбаатар<br>И.Эрдэнэбаатар |
| 291 | 5.1.15 | Байгаль орчны мэдээллийн санг төрөлжүүлэн баяжуулж, байгалийн нөөцийн мониторинг хийх ажилд орчин үеийн техник, мэдээллийн технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ. | 1. Байгаль орчны мэдээллийн санг төрөлжүүлэн өргөтгөх, мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх арга хэмжээ авна.<br>2. Байгаль орчны мэдээллийг ашиглахад орчин үеийн программ зохиомжийн шинэ технологийг нэвтрүүлнэ. | 2005-2008<br>2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>И.Эрдэнэбаатар |
| 292 | 5.1.16 | Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад онцгой үүрэг бүхий амьтан, ургамлын зүйлийг судлах, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлнэ. | 1. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх болон хувиргасан амьд организм, түүнийг импортлох хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.<br>2. Нууруудын загасны төрөл зүйлийн ашиглалтын нөөцийг судлан тогтоох ажлыг өргөжүүлнэ. | 2005-2007<br>2005-2007 | И.Эрдэнэбаатар Д.Одбаяр<br>И.Эрдэнэбаатар |
| 293 | 5.1.17 | Байгаль хамгаалал, аялал жуулчлалыг нягт уялдуулах замаар байгалийг байнгын эзэмшил тордолт, хараа хяналттай болгож, нутгийн хүн амд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, байгалийн аялал жуулчлал хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ. | 1. Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, аялал жуулчлалын менежментийн загвар төлөвлөгөө боловсруулна.<br>2. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, аяллын замыг тэмдэгжүүлэх сурталчилгааны материал бэлтгэх, жуулчны бүртгэл мэдээллийн болон түр нэвтрэх цэгүүдийн үйл ажиллагаа, тогтолцоог бүрдүүлнэ.<br>3. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсэд амьдардаг иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, экологийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн жижиг төслүүдийг хэрэгжүүлнэ. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | И.Эрдэнэбаатар<br>И.Эрдэнэбаатар<br>И.Эрдэнэбаатар |
| 294 | 5.1.18 | Ашигт малтмалыг байгальд ээлтэй арга, технологиор ашиглахыг дэмжиж, ашигласан орд газрын нөхөн сэргээх ажлын хяналт, урамшууллын арга, хэлбэрийг үр нөлөөтэй хослуулан хэвшүүлнэ. Энэ чиглэлээр байгаль орчныг хамгаалах болон орон нутгийн | 1. Технологи-үнэлгээ-лицензийн зарчмыг мөрдөн хэвшүүлнэ.<br>2. Эрдэс баялгийг олборлох байгальд ээлтэй дэвшилтэд технологийн жагсаалтыг гаргаж нийтэд зарлах, байгальд халтай хоцрогдсон арга технологид хориг тавих эрх зүйн орчинг бүрдүүлж ажиллана. | 2005-2008<br>2005-2008 | И.Эрдэнэбаатар Б.Жаргалсайхан<br>И.Эрдэнэбаатар Н.Баяртсайхан Б.Жаргалсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын эрх, үүргийг өндөржүүлнэ. Ашигт малтмалын орд газрын ашиглалтын лицензийг олгохдоо байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн шийдвэрлэдэг тогтолцоог боловсронгуй болгоно. Уул уурхай, орд ашиглалтын хяналт шинжилгээний хөтөлбөр, байгаль хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, даалгаврыг нийтэд ил тод хүргээмжтэй байлгана. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэгүй төслийг хэрэгжүүлэхгүй байх зарчмыг хэвшүүлнэ. | 3. Уул уурхайн орд газрын нөхөн сэргээлтийн удирдлагын менежментийг боловсронгуй болгоно. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Б.Жаргалсайхан |
| | | | 4. Уул уурхайн, орд ашиглалтын байгаль хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг олон нийтэд ил тод мэдээлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 295 | 5.1.19 | Хот, суурин газрын орчинг ойжуулах, цэцэрлэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ. | 1. Хот суурин газрын орчинд мод тарих, цэцэрлэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулна. | 2005–2006 | И.Эрдэнэбаатар Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Ойжуулах, орчноо цэцэрлэгжүүлэх ажлыг Бүх нийтийн хөдөлгөөн болгон сургууль тэгсөгчид, тэр, нийгмийн зүтгэлтэн, урлаг, спортын алдартнуудын нэрэмжит төгөл, цэцэрлэг байгуулах ажлыг дэмжинэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 296 | 5.1.20 | Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор "Цагаан тоос" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Эрдэнэт үйлдвэртэй хамтран "Цагаан тоос" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Б.Жаргалсайхан |
| | | | 2. Эрдэнэт үйлдвэрийн технологийн хаягдлыг барилгын материалын болон бусад үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар ашиглах технологийг шалгаруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Б.Жаргалсайхан |
| 297 | 5.1.21 | Хүн амыг эрүүлжүүлэх, өвчин эмгэгийг анагаах ашигтай чанар нь батлагдсан рашаан усанд хамгаалалтын горим тогтоох, түүнд эрүүл мэнд, байгаль орчин, аялал жуулчлалын байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах арга хэмжээ авна. | 1. Байгалийн рашааныг эмчилгээ, сувилгаа, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашиглах иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал, санаачлагыг дэмжинэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Рашааны ордыг түшиглэн аялал, жуулчлалын бааз байгуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг дэмжих замаар эмчилгээ, сувилгааны чиглэлийн аялал жуулчлалын сүлжээг өргөжүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Ц.Цэнгэл |
| 298 | 5.1.22 | Булаг шандны эх ундаргыг хашиж хамгаалсан, гар худаг гарган ашиглаж, бэлчээр нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа нь зогсоож, хохирлыг | 1. Гол, мөрний сав газрын зөвлөлүүдийг байгуулж, байгалийн усны ашиглалт, хамгаалалтад нутгийн иргэдийн хяналтыг өргөжүүлэх замаар гадаргын ус ашиглах дэвшилтэт менежментийг хэвшүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Усны нөөц санг хэмнэлттэй, үр ашигтай ашиглах зорилгоор ус ашиглагчдыг тоолууржуулах, усыг хэмнэлттэй зарцуулсан, усны дахин хэрэглээг хэвшүүлсэн, дэвшилтэд арга, технологийг үйлдвэрлэл, үйлчилгээндээ нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах механизмыг нэвтрүүлнэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар Ж.Наранцацралт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг тогтолцоог бий болгон мөрдөж хэвшүүлнэ. | 3. Усны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчилж, хүний үйл ажиллагааны буруугаас усны нөөцөд учирсан хохиролд нөхөн төлбөр тогтоодог журамд шилжинэ. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Малчид, иргэдийн хөрөнгөөр жил бүр 150-аас доошгүй уурхайн худаг шинээр гаргах, бага гүнтэй уст цэгийн эрэл хайгуул хийх ажлыг зохион байгуулж урамшуулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва |
| 299 | 5.1.23 | Усны тухай хуулийн дагуу усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагыг шинээр бий болгож, усны харилцааны асуудлыг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх боломжийг хангахуйц удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авна. | 1. Усны нөөцийн удирдлагын бүтцийг сайжруулж байгуулан усны нөөцийн хайгуул, судалгаа хийх, нөөцийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нөхцөл, бололцоог бүрдүүлнэ. | 2005-2006 | И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Усны салбарт хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж, байгууллагад усны барилга байгууламж, уст цэг, усан санг давуу эрхээр эзэмшүүлэх, төсөв, санхүү, татварын хөнгөлөлттэй нөхцөл, урамшуулал үзүүлэх асуудлыг судлан боловсруулна. | 2006-2008 | И.Эрдэнэбаатар |
| | | | 3. Ус ашиглалтын холбогдолтой журам, стандарт, норм нормативийг шинэчлэнэ. | 2005-2007 | И.Эрдэнэбаатар |
| | | | 4. Усны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, усны нийт болон ашиглалтын нөөц, ус бохирдолтын судалгаа, усны кадастрыг бий болгох арга хэмжээ авна. | 2005-2006 | И.Эрдэнэбаатар |

## Зургаа. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО

**6.1. Батлан хамгаалах тогтолцоог аюулгүй байдлын шинэ орчин нөхцөл, улс орны бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлж, Төрийн цэргийн бодлогын дагуу цэргийн шинэтгэлийн бодлогыг үргэлжлүүлж, цэргийн байгуулалтыг төгөлдөржүүлэн, орчин үеийн шаардлагын дагуу боловсронгуй болгон Зэвсэгт хүчнийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах ажлыг өргөжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 300 | 6.1.1 | Бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцсэн орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцоог төлөвшүүлж, түүнд орон нутгийн удирдлага, иргэдийг сургаж бэлтгэнэ. | 1. Орон нутгийн хамгаалалтын үзэл баримтлалыг боловсруулж батлагаажуулна. | 2004-2006 | М.Сономпил |
| | | | 2. Хямрал, үй олноор хөнөөх зэвсгээс ард нийтийг хамгаалах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн тогтолцоог бүрдүүлэх түүнийг улсын дайчилгааны нэгдсэн болон яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөтэй уялдуулах арга хэмжээг авч эхэлнэ. | 2005-2007 | М.Сономпил |
| | | | 3. Орон нутгийн хамгаалалтад иргэдийг сургаж бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, удирдах бүрэлдэхүүний цэрэг-стратегийн сургалт /КШС/-ыг зохион байгуулна. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 4. Цэргийн дайчилгааны нөөцийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна. | 2005-2007 | М.Сономпил |
| | | | 5. Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах үеийн зэвсэг техник, материал, хэрэгслийн захиалгыг шинэчлэн боловсруулна. | 2004-2005 | М.Сономпил |
| | | | 6. Аймгуудад дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын төвийг үе шаттайгаар байгуулж, дайчилгааны бэлтгэл нөөцийн 1, 2 дугаар зэргийн үүрэгтний сургалтыг жил бүр зохион байгуулна. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 7. Улсын дайчилгааны нэгдсэн болон яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг тодотгоно. | 2004-2008 | М.Сономпил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 301 | 6.1.2 | Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын механизмд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлнэ. | 1. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны үндсэн чиглэлийг шинэчлэн боловсруулж мөрдөнө.<br>2. Батлан хамгаалахын гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор батлан хамгаалахын атташегийн түвшинд харилцаа тогтоосон улсын хүрээг өргөжүүлнэ.<br>3. Өндөр хөгжилтэй улс орнуудад цэргийн боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагаағ боловсронгуй болгоно.<br>4. АСЕАН-ы бүсийн чуулга (АРФ)-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тэрийн болон судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.<br>5. Химийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг хориглох олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ. | 2005<br>2004-2008<br>2004-2008<br>2004-2008<br>2004-2008 | М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил<br>Н.Энхболд М.Сономпил<br>М.Сономпил |
| 302 | 6.1.3 | Цэргийн байгууламтыг төгөлдөржүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж, энхийг сахиулах болон Зэвсэгт хүчний оролцох боломж, хилийн чанадад үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлнэ. | 1. Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичигт батлан хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах саналын шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлно.<br>2. Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.<br>3. Байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл бүхий шуурхай хүчний цэргийн анги, салбарын тоог нэмэгдүүлж, бэлэн байдал, бэлтгэлжилтийг төлөвшүүлж, орчин үеийн тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоноөрөмжөөр хангана.<br>4. Зэвсэгт хүчний ангиудын байршлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан оновчтой болгоно.<br>5. Офицеруудыг удирдах байгууллага, орон нутаг, олон улсын хүчин, цэргийн анги, байгууллагад тодорхой үечлэлээр сэлгэн ажиллуулах тогтолцоог төлөвшүүлнэ.<br>6. Зэвсэгт хүчний анги салбарыг мэргэжлийн бие бүрэлдэхүүнээр хангах арга хэмжээг хэрэгжүүлж гэрээт цэргийн тоог нэмэгдүүлнэ.<br>7. Цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгож, энхийг сахиулах ажиллагаанд оролцох болон гэрээт цэрэгт оюутан, дээд боловсролтой иргэдийг элсүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2004-2008<br>2004-2008<br>2005-2008<br>2005-2008<br>2004-2008<br>2004-2008<br>2005 | М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил |
| 303 | 6.1.4 | Цэргийн хөдөлмөрийн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх, Зэвсэгт хүчнийг нийтийн хүч чармайлт шаардсан бүтээн байгуулалтад оролцуулахыг төрийн бодлогоор дэмжинэ. | 1. Цэргийн албан хаагчдыг иргэдийн нийгмийн асуудлаар улс орны хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүд, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй арга хэмжээнд хамруулна.<br>2. Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрын алжаал тайлах, сувилах зардлыг төр хариуцах тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг авна.<br>3. Зэвсэгт хүчний зарим анги салбарыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд улс орныг хамарсан бүтээн байгуулалтын ажилд оролцуулна.<br>4. Тэтгэвэрт гарсан, гарч байгаа ахмадуудын эрүүл мэндийг хамгаалах, иргэний мэргэжил эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ. | 2004-2008<br>2004-2008<br>2004-2008<br>2004-2008 | М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил<br>М.Сономпил |
| 304 | 6.1.5 | Цэргийн орчин үеийн болон уламжлалт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогыг баримтална. | 1. "Батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.<br>2. Салбарын төсвийн бүтцэд цэргийн шинжлэх ухаан технологи, хөрөнгө оруулалтын зохистой хувийг бий болгож, сургалт эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлнэ. | 2004-2008<br>2005-2006 | М.Сономпил<br>М.Сономпил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Онолын суурь болон хавсарга судалгаагаар салбарын тулгамдсан асуудлуудын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж, үр дүнг салбарын бодлого, үйл ажиллагаанд тусгана. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 4. Цэргийн хэрэгт сэргээгдэх эрчим хүчийг ашиглах технологийг нэвтрүүлнэ. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 5. Цэргийн сургалтанд мэдээллийн тэргүүний технологи бүхий сургалтын техник хэрэгслийг нэвтрүүлнэ. | 2005 оноос | М.Сономпил |
| | | | 6. Батлан хамгаалах их сургуулийг сургалт-эрдэм шинжилгээ-туршилтын төв болгон хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2004 оноос | М.Сономпил |
| 305 | 6.1.6 | Зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах арга хэмжээг шат дараатай авна. | 1. Цэрэг техникийн хамтын ажиллагааны хүрээнд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн зэвсэглэл, техникийг хэсэгчилэн шинэчлэн сайжруулна. | 2005-2006 | М.Сономпил |
| | | | 2. Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн техник хэрэгсэл, бие бүрэлдэхүүний хангамжийн асуудлыг зохих түвшинд шийдвэрлэнэ. | 2005-2006 | М.Сономпил |
| | | | 3. Зарим төрлийн зэвсэг, техникт сэргээн сайжруулах засвар үйлчилгээ хийнэ. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 4. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн үйлдвэрлэл-технологийн шинэчлэл хийх, иргэний зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг судалж, хэрэгжүүлнэ. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 5. Гадаадын тусламж болон Зэвсэгт хүчин дэх эдэлгээний хугацаа дууссан, хуучралд орсон, илүүдэлтэй байгаа зарим төрлийн зэвсэг, техникийг борлуулж, хөрөнгө төвлөрүүлэх замаар олон улсын цэргийн ажиллагаанд оролцох, энхийг сахиулах, тусгай үүрэг гүйцэтгэх анги салбаруудын зэвсэг, техник хэрэгслийг тэргүүн ээлжинд агаарын довтолгооноос хамгаалах холбоо, тагнуулын зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэн сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2004-2008 | М.Сономпил |
| 306 | 6.1.7 | Олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа, байгаль орчны бохирдол зэрэг аюул заналтай тэмцэх талаар дэлхийн хамтын нийгэмлэгээс тавьж буй хүчин чармайлтад тууштай хувь нэмэр оруулахыг эрмэлзэж ажиллана. | 1. Террорист ажиллагаатай тэмцэх үүрэг зориулалт бүхий ангийн бэлэн байдлыг дээшлүүлж, орчин үеийн тусгай зориулалтын техник хэрэгсэл, техеөрөмжөөр хангана. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 2. Олон улсын терроризмын эсрэг ажиллагаанд идэвхтэй оролцож, НҮБ-ын мандатын дор явагдаж байгаа энхийг сахиулах үйл ажиллагаан дахь Монгол Улсын оролцоог үргэлжлүүлнэ. | 2004-2008 | М.Сономпил<br>Н.Энхболд |
| | | | 3. Хямрал болон олон улсын хүмүүнлэгийн ажиллагааны үед олон улсын хүчний удирдлагатай хамтран ажиллах чадварт цэргийн анги, салбар, цэргийн албан хаагчдыг сургана. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 4. Холбогдох байгууллагуудтай хамтран цэргийн зориулалтаар ашиглаж байсан газар нутгийн урьдчилсан үзлэг тооллого хийнэ. | 2005-2008 | М.Сономпил |
| | | | 5. Терроризмтэй тэмцэх асуудлаар Монгол Улсаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх үндэсний илтгэлийг НҮБ-ын терроризмтэй тэмцэх хороонд хүргүүлж байна. | 2004-2008 | М.Сономпил<br>Н.Энхболд |
| | | | 6. Мансууруулах бодис, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын албатай хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, энэ салбарт туслалцаа авах чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд<br>М.Сономпил |
| | | | 7. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Палермогийн Конвенц, түүний протоколуудад нэгдэн орох чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд<br>Д.Одбаяр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 307 | 6.1.8 | НАТО-гийн "Энхийн төлөө түншлэл" хөтөлбөрт гишүүнээр элсэхийг эрмэлзэж ажиллана. | 1. НАТО-гийн "Энхийн төлөө түншлэл" хөтөлбөрт хамрагдах чиглэлээр ажиллах хүрээнд эхний алхам болгон НАТО-той хамтран ажиллах чиглэлийг гаргаж, төсөл хэрэгжүүлэх талаар тохиролцоо байгуулж ажиллана. | 2005-2006 | М.Сономпил Н.Энхболд |
| 308 | 6.1.9 | Зэвсэгт хүчний чадавхийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй болно. | 1. Зэвсэгт хүчнийг үе шаттайгаар хөгжүүлэх баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ. | 2005-2008 | М.Сономпил |
| 309 | 6.1.10 | Газрын минийг хориглох Оттавагийн конвенцид үе шаттайгаар нэгдэж, эхний шатанд Монгол Улсын газрын минийн тоо хэмжээ, чанар байдлыг ил тод болгоно. | 1. Газрын минийг хориглох Оттавагийн конвенцид үе шаттайгаар нэгдэн орох Монгол Улсын төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулна. | 2005-2006 | М.Сономпил |
| | | | 2. "Ил тод" /transparency/ байх зорилгоор Конвенцэд нэгдэн ороогүй орнууд өөрсдийн газрын минийн талаарх илтгэлээ сайн дурын үндсэн дээр гаргаж өгөх боломжтой тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 58/53 дугаар тогтоол, Оттавагийн Конвенцийн 7 дугаар зүйлд заасны дагуу үндэсний илтгэлээ гаргаж өгнө. | 2007 | М.Сономпил Н.Энхболд |
| | | | 3. Одоо зэвсэгт хүчинд хадгалагдаж байгаа ЯЦЭМ-ийн байдал устгах нөхцөл, түүнд зориулагдах хугацаа болон зардлын талаар холбогдох судалгаа хийж, үнэлэлт өгөхөд гадаад орон, олон улсын байгууллагаас санхүүгийн дэмжлэг авах талаар идэвхтэй ажиллана. Газрын минийн чанар байдалд гадаад орон, олон улсын байгууллагын шинжээчидтэй хамтран үнэлгээ дүгнэлт өгнө. | 2006-2008 | М.Сономпил |
| | | | 4. Газрын минийг хориглох Оттавагийн конвенцид үе шаттайгаар нэгдэх стратеги, бодлого төлөвлөгөө боловсруулж, энэ чиглэлээр Канад зэрэг оронтой хамтран ажиллана. | 2008 | М.Сономпил Н.Энхболд |
| | | | 5. Монголын Зэвсэгт хүчинд байгаа газрын минийн нэгдсэн тооллого явуулж, газрын минийн чанар байдлыг тодорхойлоход гадаадын экспертийг оролцуулах талаар ажиллана. | 2005-2008 | М.Сономпил Н.Энхболд |
| 310 | 6.1.11 | Газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох атар газрыг минээс чөлөөлөхөд олон улсын байгууллагын дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | |
| 311 | 6.1.12 | НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны шаардлага хангасан мото буудлагын батальоныг бэлтгэн шаардагдах зэвсэг, техникээр хангаж, НҮБ-ын мандат бүхий энхийг сахиулах ажиллагаанд оролцоно. | 1. НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны шаардлага хангасан мотобуудлагын нэг батальоныг бэлтгэж, цэрэг, цагдаагийн 1 рот байгуулж, шаардагдах зэвсэг, техникээр хангаж, НҮБ-ын мандаттайгаар энхийг сахиулах ажиллагаанд оролцуулна. | 2004-2008 | М.Сономпил Н.Энхболд |
| | | | 2. НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцох цэргийн баг, ажиглагч, мэргэжилтэн нарын нөөцийг нэмэгдүүлж, оролцоог өргөжүүлэн, энэ үйл ажиллагаанд оролцох манай чадварыг бэхжүүлэх чиглэлээр гадаад орнуудтай хамтран ажиллана. | 2004-2008 | М.Сономпил Н.Энхболд |
| | | | 3. Гуравдагч оронтой Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцох урьдчилсан гэрээ байгуулах чиглэлээр ажиллана. | 2004-2008 | М.Сономпил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 4. Хүмүүнлэгийн ажиллагаанд оролцох инженерийн салааг сургаж бэлтгэнэ. | 2005-2008 | М.Сономпил |
| | | | 5. НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд цэргийн баг оролцох нөхцөлд дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн шаардагдах эрх зүйн зохицуулалтыг хийнэ. | 2005-2008 | М.Сономпил Н.Энхболд |
| 312 | 6.1.13 | Зэвсэгт хүчний сургуулийн нэгдсэн төвийг олон улсын хэмжээний төрөл бүрийн цэргийн сургалт явуулах шаардлагад нийцүүлэн үндэсний сургалтын төв болгон өөрчилнө. | 1. Таван толгой дахь Зэвсэгт хүчний нэгдсэн сургалтын төвийг бүс нутгийн энхийг сахиулах ажиллагааны сургалтын төв болгон өргөжүүлж, хоёр болон олон талын хамтарсан дадлага, сургуулийг зохион байгуулна. | 2004-2008 | М.Сономпил |
| | | | 2. Гадаад улсуудтай энхийг сахиулах болон олон улсын хүмүүнлэгийн ажиллагааны чиглэлээр хамтарсан сургалт, дадлага явуулна. | 2005-2008 | М.Сономпил |
| | | | 3. Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн орны энхийг сахиулах ажиллагааны сургуулийг үндэсний сургалтын төвд уламжлал болгон зохион байгуулах талаар идэвхтэй ажиллана. | 2004-2008 | М.Сономпил |
| **6.2. Гамшгаас хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлж, гамшгаас хамгаалах, тухайлбал, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 313 | 6.2.1 | Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | 1. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. | 2004 | ОБ-ын сайд |
| | | | 2. Улсын нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулна. | 2005 | ОБ-ын сайд |
| | | | 3. Гамшгаас хамгаалах, гамшгийн аюултай тэмцэх олон улсын конвенцид нэгдэн орох асуудлыг шийдвэрлэнэ. | 2005 | ОБ-ын сайд |
| | | | 4. Гамшгаас хамгаалах талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулж батлуулна. | 2005 | ОБ-ын сайд |
| | | | 5. Гамшгаас хамгаалах хөтөлбөрийг боловсруулна. | 2005 | ОБ-ын сайд |
| 314 | 6.2.2 | Гамшиг судлалын ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах боловсролыг иргэдэд олгох, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх тогтолцоог бий болгоно. | 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт гамшгаас хамгаалах үзүүлэх сургууль, дадлагыг тогтмол зохион байгуулна. | 2004 оноос | ОБ-ын сайд Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Гамшгаас хамгаалах талаар онолын суурь болон хавсарга судалгаар хөгжүүлнэ. | 2006 | ОБ-ын сайд Ө.Энхтүвшин |
| | | | 3. Гамшгийн судалгааны байгууллагыг тусгай хөтөлбөрөөр хөгжүүлж, эрдэм шинжилгээ, туршилт, үйлдвэрлэлийн материаллаг баазыг бэхжүүлнэ. | 2005 | ОБ-ын сайд |
| | | | 4. Гамшгийн судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг гамшгаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлнэ. | 2006 | ОБ-ын сайд Ө.Энхтүвшин |
| | | | 5. Шинжлэх ухаан, технологийн өндөр хөгжилтэй орнуудын гамшгийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлнэ. | 2005 оноос | ОБ-ын сайд Н.Энхболд |
| | | | 6. Иргэдэд гамшгаас хамгаалах боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ. | 2006 | ОБ-ын сайд Н.Энхболд |
| | | | 7. Гамшгаас хамгаалах салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлыг судалж, эхлэлийг тавина. | 2006 | ОБ-ын сайд Н.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 315 | 6.2.3 | Гамшгийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг боловсронгуй болгож мэдээллийн сан байгуулна. | 1. ОБЕГ-т ашиглагдаж байгаа богино долгионы радиостанцуудыг радио модемоор сүлжээнд холбож мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.<br>2. Аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штабт ашиглагдаж байгаа богино долгионы IC-78 радиостанцуудыг ашиглан байгууллагын компьютерийн дотоод сүлжээнд холбож иж бүрэн мэдээлэл, холбооны техник хэрэгсэл бүхий хөдөлгөөнт 5-6 зангилгаар бүсийн төвүүдэд байгуулна.<br>3. Сансрын технологийг ашиглан гамшгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.<br>4. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын мэдээллийн техник болон программ хангамж, нэгдсэн сан, сүлжээг өргөтгөн сайжруулж геомэдээллийн системийг нэвтрүүлнэ.<br>5. "Гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээлэл"-ийг улсын хэмжээнд ашиглагдаж байгаа бүх төрлийн мэдээлэл, холбооны сүлжээгээр дамжуулах тогтолцоо бүрдүүлнэ. | 2005 оноос<br>2006 оноос<br><br>2007 оноос<br>2005 оноос<br><br>2005 оноос | ОБ-ын сайд С.Батболд<br>ОБ-ын сайд С.Батболд<br><br>ОБ-ын сайд С.Батболд<br>ОБ-ын сайд<br><br>ОБ-ын сайд С.Батболд |
| 316 | 6.2.4 | Гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлэх, гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг дээшлүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана. | 1. ОХУ-ын гал эсэргүүцэх шинжлэх ухаан, шинжилгээ судалгааны хүрээлэнтэй байгуулсан харилцааг сэргээж, галын шинжлэх ухаан-технологийн салбарт хамтран ажиллах боловсон хүчин сургаж дадлагажуулах асуудлыг шийдвэрлэнэ.<br>2. Хил орчмын болон хил дамнан үүссэн гамшиг, онцгой байдлын үед харилцан мэдээлж, хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээрийг Монгол улстай хил залгаа оршдог ОХУ-ын муж, Бүгд найрамдах улсуудтай зохих түвшинд байгуулна.<br>3. ОХУ-ын Холбооны нөөцийн агентлагтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээрийг шинэчлэн байгуулж, Сибирийн тойргийн Нөөцийн газартай шууд харилцаа тогтоож, хамтран ажиллана.<br>4. Гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг бүх шатанд солилцоно.<br>5. БНХАУ-ын гамшиг, осолтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлнэ.<br>6. Швейцарийн Холбооны Улсын Иргэний хамгаалалтын байгууллагатай харилцаа тогтоож, хамтын ажиллагаа хөгжүүлнэ.<br>7. ХБНГУ-ын гамшигтай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцаа тогтоох асуудлыг судалж шийдвэрлэнэ.<br>8. Гадаад орнуудтай техник, хамтын ажиллагааны хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судалж шийдвэрлэнэ. | 2005 оноос<br><br>2005 оноос<br><br>2005 оноос<br><br>2005 оноос<br>2004<br>2004 оноос<br>2005 оноос<br>2006 оноос | ОБ-ын сайд Ө.Энхтүвшин<br><br>ОБ-ын сайд<br><br>ОБ-ын сайд<br><br>ОБ-ын сайд<br>ОБ-ын сайд Н.Энхболд<br>ОБ-ын сайд Н.Энхболд<br>ОБ-ын сайд Н.Энхболд<br>ОБ-ын сайд Н.Энхболд |
| 317 | 6.2.5 | Тусгай үүрэгтэй гамшгаас хамгаалах ангиудын техник хэрэгслийн хангалт, хүн хүчний бэлтгэл хангамжид онцгой анхаарал хандуулна. | 1. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг гамшгийн үед зайлшгүй шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.<br>2. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын сургалтад агуулга, стандартын өөрчлөлт хийж, гамшигтай тэмцэх арга техникт сургах цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2005 оноос<br><br>2005 оноос | ОБ-ын сайд Аймаг, нийслэлийн Засаг дарга<br><br>ОБ-ын сайд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Бүсчилсэн хөгжлийн тулгуур төвийг түшиглэн гамшгаас хамгаалах бүс нутгийн хамтын ажиллагааг төлөвшүүлж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлнэ. | 2006 оноос | ОБ-ын сайд<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 4. Үндэсний гамшгийн удирдлагын чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор гамшигтай тэмцэх салбаруудын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх санал боловсруулна. | 2005 оноос | ОБ-ын сайд |
| 318 | 6.2.6 | Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор хөрөнгө, хүчийг захиран зарцуулах оновчтой механизмыг бүрдүүлнэ. | 1. Бүсчилсэн хөгжлийн тулгуур төвүүдийн хими-инженер, холбоо, уснаас аврах зориулалтын багаж тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулна. | 2006 оноос | ОБ-ын сайд |
| | | | 2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг бүс нутгийн онцлог нөхцөлтэй уялдуулан зохион байгуулна. | 2004 оноос | ОБ-ын сайд<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх тусгай журам боловсруулж мөрдөнө. | 2005 оноос | ОБ-ын сайд<br>Ө.Энхтүвшин |
| 319 | 6.2.7 | Аврах, гал унтраах, сэргээн босгох ангиудыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, эрж хайх, аврах, сэргээн босгох чиглэлээр сургаж бэлтгэнэ. | 1. Аврах тусгай анги, Хэнтий аймгийн Гамшгаас хамгаалах штабыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, эрэн хайх, аврах, сэргээн босгох чиглэлээр сургаж загвар анги, штабын түвшинд хүргэнэ. | 2005 оноос | ОБ-ын сайд |
| | | | 2. Эрэн хайх, сэргээн босгох чиглэлээр аврагч нарыг сургаж бэлтгэн Аврах тусгай анги, аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штабыг түшиглэн эрэн хайх, аврах, сэргээн босгох нэгжүүдийг байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | 2005 оноос | ОБ-ын сайд<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслийн хүрээнд ой, хээрийн түймэр гарах магадлал өндөртэй 17 аймгийн Гамшгаас хамгаалах штабыг ой, хээрийн түймэртэй тэмцэх техник зэвсэглэмж, багаж хэрэгслээр хангаж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын чадавхийг нэмэгдүүлнэ. | 2005 оноос | ОБ-ын сайд<br>Н.Баяртсайхан<br>Н.Энхболд |
| | | | 4. Төвлөрсөн суурин газруудад обьектын гал түймэр унтраах техник, технологийг боловсронгуй болгоно. | 2005 оноос | ОБ-ын сайд<br>Ж.Наранцацралт |
| 320 | 6.2.8 | Улсын болон орон нутгийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршлыг оновчтой болгоно. | 1. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үед шаардагдах зарим материал хэрэгслийн гамшгийн нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх, аймаг, сумдад байвал зохих нөөцийн жагсаалтыг гарган байнгын нөөцтэй байлгах арга хэмжээ авч, эрх зүй, санхүүгийн орчинг боловсронгуй болгоно. | 2005 оноос | ОБ-ын сайд<br>Н.Баяртсайхан |
| | | | 2. Улс, аймгийн өөс, тэжээлийн нөөцийг хадгалах нөхцөлийг сайжруулах, нөөцийг бүрдүүлэх, түүний чанарыг сайжруулах арга хэмжээ авна. | 2005 оноос | ОБ-ын сайд<br>Д.Тэрбишдагва |
| | | | 3. Бүс нутгуудад аймаг дундын отрын нөөц бэлчээрийг тогтоож цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд мал өвөлжүүлэх, хаваржуулах арга хэмжээ авна. | 2004 оноос | ОБ-ын сайд<br>Д.Тэрбишдагва |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 4. Стратегийн ач холбогдол бүхий хүнсний улаан буудайн нөөцийг бүрдүүлнэ. | 2005 оноос | ОБ-ын сайд Д.Тэрбишдагва |
| | | | 5. Улсын нөөцийн байршил, нэр төрөл, тоо хэмжээг боловсронгуй болгох асуудлыг боловсруулж шийдвэрлэнэ. | 2005-2008 | ОБ-ын сайд |
| | | | 6. Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлнэ. | 2006-2008 | ОБ-ын сайд |
| 321 | 6.2.9 | Иргэд, олон нийтэд тулгуурласан гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлнэ. | 1. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглан явуулах арга хэлбэрийг боловсронгуй болгоно. | 2005 оноос | ОБ-ын сайд |
| | | | 2. Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагыг хөхиүлэн дэмжинэ. | 2005 оноос | ОБ-ын сайд |
| | | | 3. Радио, телевизийн нэвтрүүлэг, сонин хэвлэлийн нийтлэлийн бодлогыг иргэд олон нийтийн аюулгүй амьдрах арга, ухаанд чиглүүлэх ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. | 2004 оноос | ОБ-ын сайд |
| | | | 4. Улс орны эдийн засагт нөлөөлөхүйц томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад гамшиг, ослын үеийн урьдчилан үнэлгээ хийх, найдвартай ажиллагааг хангах цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005 оноос | ОБ-ын сайд |
| | | | 5. Хүүхэд, өсвөр үеийнхний дунд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх талаар НҮБ-ын Хүүхдийн сан бусад байгууллагатай хамтран тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2005-2008 | ОБ-ын сайд Аймаг, нийслэлийн Засаг дарга |

**Долоо. ГАДААД БОДЛОГО**

**7.1 Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэн, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын зарчмуудыг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулж, өөрийн орны язгуур эрх ашиг, түүний дотор иргэд, аж ахуйн нэгжүүдийн хууль ёсны эрх ашгийг гадаадад тууштай хамгаалж байх зарчмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 322 | 7.1.1 | Дэлхийн улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх гадаад бодлогын уламжлал, залгамж чанарыг хадгалан ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлнэ. | ОХУ-тай | | Н.Энхболд |
| | | | 1. Уламжлалт түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт урагшлуулан хөгжүүлнэ. | 2005-2008 | |
| | | | 2. Өндөр, дээд хэмжээний айлчлал, уулзалтын давтамжийг хадгалж, яриа хэлэлцээг бүх түвшинд тогтмолжуулна. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 3. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн Газар Хоорондын Комисс, түүний дэд комиссуудын хуралдаануудын үйл ажиллагааг идэвхжүүлэн, үр ашигтай ажиллуулах чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Б.Жаргалсайхан Н.Энхболд |
| | | | 4. Хоёр талын харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 5. ОХУ-ын хил орчмын болон бусад субъектуудтэй тогтоосон хамтын ажиллагааг идэвхжүүлж, хилийн худалдааг эрчимжүүлэхийг дэмжинэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан Н.Энхболд |
| | | | 6. ОХУ-тай боловсрол соёл, шинжлэх ухааны салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | 2005-2008 | Ө.Энхтүвшин Н.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 7. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа ОХУ-ын болон ОХУ-д байгаа Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн асуудлыг зохицуулах чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд<br>Н.Баяртсайхан |
| | | | 8. ОХУ-тай харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 9. БНХАУ-тай сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг бүх салбарт урагшлуулан хөгжүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 10. БНХАУ-тай өндөр, дээд хэмжээний айлчлал, уулзалтын давтамжийг хадгалж, яриа хэлэлцээг бүх түвшинд тогтмолжуулна. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 11. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын хуралдааны шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, тусламжийг үр ашигтай ашиглахад түлхүү анхааран ажиллана. | 2005-2008 | Ц.Цэнгэл<br>Н.Энхболд |
| | | | 12. БНХАУ-тай боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Ө.Энхтүвшин<br>Н.Энхболд |
| | | | 13. Монгол, Хятадын хил орчмын бүс нутгийн аймаг, муж, хотуудын шууд харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд туслалцаа үзүүлнэ. | 2004-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |
| | | | 14. БНХАУ-тай харилцах дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2004-2008 | Н.Энхболд |
| 323 | 7.1.2 | Хөрш орнуудын болон олон улсын зах зээлийн боломжийг илүүтэй ашиглах, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд экспортлох бараа, бүтээгдэхүүнийг татваргүй нийлүүлэх боломжийг эрэлхийлэн ажиллана. | 1. ОХУ-ыг Дэлхийн Худалдааны Байгууллагад элсэх ажлын хүрээнд худалдааг либералчлах асуудлын талаарх яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийнэ. | 2005-2008 | Б.Жаргалсайхан |
| | | | 2. Дамжин өнгөрөх тээврийн талаар Монгол-Орос-Хятад гурван талын хэлэлцээр байгуулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд<br>Ц.Цэнгэл |
| 324 | 7.1.3 | Худалдааны нэн таатай нөхцөлийг худалдааны түнш зарим оронд тавьж шийдвэрлүүлэн гадаад зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээ авна. Хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, тодорхой орнуудтай харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Өндөр хөгжилтэй орнуудын томоохон хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд<br>Н.Баяртсайхан |
| | | | 2. АНУ, Япон, БНСУ, ХБНГУ, Европын Холбоо, Энэтхэгтэй харилцааны дунд хугацааны нэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд<br>Н.Баяртсайхан |
| | | | 3. Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг Тайланд, Хорват, Словак, Канад зэрэг улстай байгуулах чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |
| | | | 4. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийг Япон, Тайланд, Египет, Бразил, Чили, Узбекистан, Азербайжан, Латви, Литва, Хорват, Словени зэрэг улстай байгуулах чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Баяртсайхан<br>Н.Энхболд |
| 325 | 7.1.4 | АНУ, Япон, БНСУ, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, тэдний бодит сонирхлыг Монголд бий болгон тэдгээр оронтой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, "Мянганы сорилтын хөтөлбөр"-ийн | 1. АНУ-тай өндөр, дээд хэмжээний уулзалтыг тогтмолжуулах, яриа хэлэлцээг идэвхжүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 2. Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэх, энэ хэлэлцээрийн дагуу байгуулах Монгол-АНУ-ын хамтарсан зөвлөлийн хурлыг зохион явуулна. Япон, Герман зэрэг орнуудтай худалдаа, эдийн засгийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулна. | 2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |
| | | | 3. Өндөр, дээд хэмжээний уулзалтыг тогтмолжуулах, яриа хэлэлцээг идэвхжүүлэх чиглэлээр Япон Улстай ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүрээнд тусламж авах чиглэлээр ажиллана. | 4. Мэдээллийн технологийн мастер төлөвлөгөөг БНСУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд боловсруулна.<br>5. ХБНГУ-тай өндөр, дээд хэмжээний уулзалтыг тогтмолжуулах, яриа хэлэлцээг идэвхжүүлэх чиглэлээр ажиллана.<br>6. Зарим муж, улсуудын бизнесийн төлөөлөгчдийг айлчлуулах, Герман зэрэг гадаад орнуудад зохиогддог яармаг, үзэсгэлэнд тогтмол оролцох замаар бизнесийн хүрээнийхний хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | С.Батболд<br>Н.Баяртсайхан<br>Н.Энхболд<br>Н.Энхболд<br>Б.Жаргалсайхан<br>Н.Энхболд |
| 326 | 7.1.5 | Иж бүрэн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд эдгээр улс оронтой улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбарт бүх талын харилцааг идэвхжүүлэн өргөжүүлнэ. Худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. | 1. Эдгээр орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээр, тохиролцоонуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.<br>2. Эдгээр орнуудтай байгуулсан хоёр талын механизмуудын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008<br>2005-2008 | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан<br>Н.Энхболд<br>Н.Энхболд<br>Сайд нар |
| 327 | 7.1.6 | Монгол, Европын Холбооны харилцааны түвшинг ахиулах, Ази, Латин Америкийн хөгжилтэй ... хөтөлбөрийн хүрээнд хамтын ажиллагаагаа хөгжүүлж, авч буй тусламжийн хэмжээг бууруулахгүй байх зорилт тавин ажиллана. Европын Холбооны гишүүн орнуудтай хөгжүүлж ирсэн хоёр талын хамтын ажиллагаар гүнзгийрүүлэн бататгахын зэрэгцээ хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх чиглэл баримтална. | 1. Европын холбооны гишүүн орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх, боловсрол, соёл, шинжлэх ухаан, байгаль орчин, эрүүл мэнд, спорт зэрэг боломжоотой бүхий л салбарт хамтран ажиллах, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах чиглэлээр ажиллана.<br>2. Монгол, Европын Холбоо хоорондын өндөр, дээд хэмжээний айлчлалууд, Хамтарсан хороодын хуралдаан, улс төрийн яриа хэлэлцээний давтамжийг тогтмолжуулах, харилцааг хоёр талын тэнцүү үрсгалтай болгох чиглэлээр ажиллана.<br>3. Европын Комиссоос баталсан "Зах зээлийн бус эдийн засагтай орнууд"-ын жагсаалтаас Монгол Улсыг хасуулах чиглэлээр үргэлжлүүлэн идэвхтэй ажиллана.<br>4. Европын Холбооны зах зээлд Монголын экспортыг нэмэгдүүлэх, мах, малын дайвар бүтээгдэхүүн экспортлох асуудлыг судална.<br>5. Үхрийн тархи сархиагтах (BSE) өвчний талаарх Европын Комиссоос 2001 онд гаргасан жагсаалтын үхрийн BSE өвчин байхгүй орон буюу "Ангилал 1"-д Монгол Улсыг оруулах чиглэлээр Европын холбоотой хамтарч үргэлжлүүлэн ажиллана. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | Н.Энхболд<br>Ж.Наранцацралт<br>Сайд нар<br>Н.Энхболд<br>Н.Энхболд<br>Б.Жаргалсайхан<br>Б.Жаргалсайхан<br>Д.Тэрбишдагва<br>Н.Энхболд<br>Д.Тэрбишдагва<br>Н.Энхболд |
| 328 | 7.1.7 | Ази, Номхон далайн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаар хөгжүүлэн бэхжүүлэхийн зэрэгцээ бүс нутаг, түүнчлэн Зүүн хойд Ази, Төв Азийн олон талт үйл явц, яриа хэлэлцээ, интеграцид үр ашигтай оролцох оновчтой хэлбэрийг сонгон авч, бүс | 1. Энэтхэг, АСЕАН-ы гишүүн орнууд зэрэг бүсийн улс орнуудтай хоёр талын шугамаар харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлнэ.<br>2. АРФ-ын үйл явц дахь манай оролцоог идэвхжүүлэх чиглэлээр ажиллана.<br>3. Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөлгөөн, Азид хамтран ажиллах яриа хэлцээний хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцоно. | 2004-2008<br>2004-2008<br>2004-2008 | Н.Энхболд<br>Н.Энхболд<br>Н.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нутгийн тогтвортой байдлыг хангах, бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэл баримтална. | 4. Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагаанд ажиглагчийн статустай оролцоно. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 5. АСЕМ-д элсэх чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 6. ПЕКК-т гишүүнчлэлээ жинхэлүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 7. "Зүүн хойт Азийн яриа хэлцээ" албан бус механизмд хамрагдах чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 8. Зүүн Хойд Азийн эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх хүчин чармайлтыг дэмжиж ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд<br>Б.Эрдэнэбат |
| | | | 9. "АСЕАН+3"-тай хамтран ажиллах боломжийг судлах үүднээс холбогдох талуудтай зөвлөлдөнө. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 10. Зүүн хойд Азийн орнуудын Түмэн бүс хөтөлбөрийн хүрээнд Монголын Дорнод бүс нутгийн нөөцийг хоршин ашиглаж, эрчимтэй хөгжүүлэх олон улсын стратегийн төслийг боловсруулан дунд хугацааны бодлогод тусган хэрэгжүүлнэ. | 2005 оноос | Н.Баяртсайхан<br>Н.Энхболд |
| | | | 11. Бүс нутгийн хамтын ажиллагаагаар дамжуулан Монгол Улсын гадаад худалдаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, өргөжүүлэх чиглэлээр ажиллана. | 2005 оноос | Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан |
| | | | 12. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц, "Хүүхдэд зэлтэй Дэлхий ертөнц" Тунхаглалын хэрэгжилтээр Ази, Номхон далайн бүсийн туршлага, мэдээлэл солилцох олон улсын бага хурлыг зохион байгуулна. | 2006 | Н.Энхболд |
| 329 | 7.1.8 | АПЕК-ийн ажлын хэсгүүдэд манай улсын оролцоог идэвхжүүлж, тус байгууллагад гишүүнээр элсэх зорилт тавьж ажиллана. | 1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд<br>Б.Жаргалсайхан<br>Ц.Цэнгэл |
| | | | 2. АПЕК-т гишүүнээр элсэх хүсэлтээ дэмжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд |
| 330 | 7.1.9 | Монгол Улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах, улс орны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ, түүний төрөлжсөн болон системийн байгууллагууд, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон улсын нөлөө бүхий байгууллагуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаар бататган хөгжүүлэхийг зорино. | 1. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг хуульчлан баталгаажуулах гурван талт гэрээний төслийг шинэчлэн боловсруулна. Гэрээ байгуулах хүч чармайлтыг Олон улсын эрх зүй зан заншлын хэм хэмжээ болгох арга замтай хослуулан ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 2. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын баталгааг хууль эрх зүйн хувьд авахын тулд цөмийн зэвсэгтэй таван гүрэн, НҮБ-тай зөвлөлдөнө. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 3. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах асуудлыг дэмжсэн тухай заалтыг НҮБ, түүний системийн байгууллагуудын баримт бичгүүд болон хоёр талын хамтарсан мэдэгдлүүдэд тусгаж байх талаар үргэлжлүүлэн ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 4. НҮБ-ын Нарийн Бичгийн дарга нарын газраас гаргасан манай улсын эдийн засгийн эмзэг байдал, экологийн аюулгүй байдлын талаар хийсэн 2 судалгааны дунд гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд<br>Сайд нар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үйл ажиллагаанд оролцоход баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 6. Мянганы хөгжлийн зорилтуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах механизм байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Мянганы Хөгжлийн Зорилтуудын үндэсний хэрэгжилтийн тухай илтгэл, мэдээллийг НҮБ-д гаргаж өгч байна. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 7. Улс орны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ, түүний системийн байгууллагуудтай хамтын ажиллагааны хөтөлбөр байгуулж ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |
| 331 | 7.1.10 | Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын V бага хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой үйл ажиллагаа явуулж, тус хөдөлгөөнд оролцогч орнуудтай идэвхтэй хамтран ажиллана. | 1. V бага хурлаас баталсан Улаанбаатарын Тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөрийг олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр НҮБХХ-тэй хамтран баталсан "Ардчиллыг Шинээр Сэргээн Тогтоосон Орнуудын олон улсын V бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх нь" төслийг хэрэгжүүлнэ. | 2004-2006 | Н.Энхболд |
| | | | 2. Ардчиллын хамтын нөхөрлөлийн орнуудын хөдөлгөөнтэй Ардчиллыг Шинээр Сэргээн Тогтоосон Орнуудын хөдөлгөөнийг ойртуулах талаар Мали болон зохион байгуулах бүлгийн бусад улс оронтой харилцан ажиллана. | 2004-2006 | Н.Энхболд |
| | | | 3. Катар Улсын Доха хотноо болох Ардчилал Шинээр Сэргээн Тогтоосон Орнуудын VI бага хуралд V бага хурлыг даргалагч Монгол Улсын илтгэлийг боловсруулж өргөн барина. | 2006 | Н.Энхболд |
| 332 | 7.1.11 | Уламжлалт харилцаатай орнуудтай шинэ нөхцөлд зохицуулан сэргээн хөгжүүлж буй харилцаанд гарсан ахицыг бататгаж, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх чиглэлээр ажиллана. | 1. Уламжлалт харилцаатай орнуудтай улс төрийн яриа хэлэлцээг үргэлжлүүлж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, үүний дотор худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, давхар татвар ногдуулахаас зайлсхийх, хөренгө оруулалтыг харилцан хамгаалах болон бусад хэлэлцээрүүдийг байгуулах чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд<br>Б.Жаргалсайхан<br>Н.Баяртсайхан |
| | | | 2. Өндөр, дээд хэмжээний айлчлалуудыг тогтмолжуулах чиглэл барьж ажиллана. | 2004-2008 | Н.Энхболд |
| 333 | 7.1.12 | Гадаадад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах механизмыг боловсронгуй болгох, Консулын албыг бэхжүүлэх арга хэмжээг авна. | 1. Монгол иргэд гадаадад зорчих, хөдөлмөр эрхлэх, сурах, оршин суух таатай нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчин бий болгох ажлыг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд<br>Л.Одончимэд |
| | | | 2. Иргэд гадаадад зорчихад шаардагдах мэдээлэл, гадаад оронд хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх ашиг, сонирхлоо хамгаалуулахад чиглэсэн ажлыг зохион байгуулж, энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээр өргөн сурталчилна. | 2005-2008 | Н.Энхболд<br>Л.Одончимэд |
| | | | 3. Монголын иргэд гадаад оронд гачигдал зовлон тохиолдоход тусламж, дэмжлэг үзүүлэх сан байгуулах боломжийг судална. | 2005-2008 | Н.Энхболд<br>Н.Баяртсайхан |
| | | | 4. Орчин үеийн мэдээллийн технологи, техникийг консулын үйл ажиллагаанд өргөн нэвтрүүлэн ашиглана. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 5. Консулын албаны эрх зүйг төгөлдөржүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 6. Гадаад орнуудын Гадаад хэргийн яамны Консулын албадтай хийх Консулын зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулна. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 7. Өргөмжит консулын албыг өргөтгөх, эрх зүйн орчныг нь төгөлдөржүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 8. Зарим консулын албадын иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаатай танилцаж, заавар, зөвлөгөө өгөх, гадаадад амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хөндсөн иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг судлан шийдвэрлүүлнэ. | 2005- 2006 | Д.Одбаяр<br>Н.Энхболд |
| 334 | 7.1.13 | Дипломат албыг төрийн мэргэшсэн тусгай албын хувьд эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгааллын чиглэлээр бэхжүүлж, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний өндөр мэдлэгтэй боловсон хүчнээр хуулийн хүрээнд сэлбэх журмыг тууштай хэрэгжүүлнэ. | 1. Боловсон хүчний бодлого, давтан сургалтын хөтөлбөрт шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тусгаж батлуулан мөрдөнө. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 2. Дипломат албаны тухай хууль, системийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа журам, зааврын хэрэгжилтийг сайжруулах тодорхой ажил зохионо. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 3. Боловсон хүчний нэгдсэн болон төрөлжсөн судалгааг үндэслэл сайтай боловсруулна. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 4. Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж төрийн мэргэшсэн тусгай албаны статус, албан хаагчдын эрх ашиг, нийгмийн баталгааг хуульчлан хангах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. | 2005 | Н.Энхболд |
| 335 | 7.1.14 | Монгол Улсын дипломат төлөөлөгчдийн газруудын байршлыг илүү оновчтой, үр ашигтай болгох, дипломатуудын ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах талаар санал боловсруулж, шат дараатай хэрэгжүүлнэ. | 1. Дипломат төлөөлөгчдийн газруудын байршил, бүтэц, орон тоо, чиг үүрэг, улс төрийн болон бусад ашиг сонирхлын ач холбогдлыг тооцсон судалгаа гарган, санал боловсруулж танилцуулна. | 2004-2005 | Н.Энхболд |
| | | | 2. Дипломат төлөөлөгчдийн газруудыг Итали, Австрали, Скандинавын аль нэг оронд шинээр нээх боломжийг судална. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 3. Дипломат төлөөлөгчдийн газруудыг мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангах ажлыг холбогдох бусад байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 4. Сингапур Улс дахь Ерөнхий Консулын Газрыг Элчин Сайдын Яам болгон статусыг нь дээшлүүлнэ. | 2005 | Н.Энхболд |
| | | | 5. Дипломат төлөөлөгчдийн газруудын тэргүүн, нэгжийн ажлын үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгох арга хэмжээ авна. | 2005-2008 | Н.Энхболд |
| 336 | 7.1.15 | Монголын түүх, соёл, өнөөгийн байдлыг гадаад ертөнцөд сурталчлах, Монголын тухай зөв ойлголтыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулна. | 1. Гадаад сурталчилгааны арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөх, зохицуулах механизм бий болгоно. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 2. Гадаад сурталчилгааны үндсэн чиглэлийг боловсруулна. | 2005-2008 | Н.Энхболд |
| | | | 3. Монголын талаарх олон нийтийн ойлголтын тухай судалгааг зарим оронд хийнэ. | 2005-2008 | Н.Энхболд |

## Найм. ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ

**8.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, иргэдийн амгалан тайван аюулгүй байдлыг хангах талаар орон нутгийн эрх мэдлийг өргөжүүлж, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно. Энэ зорилтын хүрээнд:**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 337 | 8.1.1 | Нийгмийн бүх шатанд авилгалтай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, албан тушаалын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд чиглэсэн үр дүнтэй систем бүрдүүлнэ. | 1. Эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах албаны авилгал, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үүрэгтэй нэгжийн бүтцийг өөрчлөн зохион байгуулж прокурор, шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдыг мэргэшүүлэх сургалтад үе шаттай хамруулна.<br>2. Авилгал, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх үүрэг бүхий албадыг орчин үеийн техник, шаардлагатай хүч хэрэгслээр үе шаттайгаар хангана.<br>3. Авилгалын эсрэг хуулийг шинэчлэн боловсруулна.<br>4. Авилгал, албан тушаалын болон зохион байгуулалттай бусад гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар судалгаа хийж, эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар санал зөвлөмж гаргана. | 2005–2007<br>2005–2008<br>2005- 2006<br>2005–2007 | Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр |
| 338 | 8.1.2 | НҮБ-ын авилгалын эсрэг конвенцид нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлэнэ. | 1. Уг конвенцид нэгдэх асуудлыг судалж, шийдвэрлэнэ. | 2005-2008 | Н.Энхболд<br>Д.Одбаяр |
| 339 | 8.1.3 | Албан тушаалтнуудын орлогын мэдүүлгийг нээлттэй болгоно. | 1. Төрийн албан хаагчийн орлогын мэдүүлгийг нээлттэй болгох чиглэлээр Авилгалын эсрэг хуульд тусгах асуудлыг судалж шийдвэрлүүлнэ. | 2005- 2006 | Д.Одбаяр |
| 340 | 8.1.4 | Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлж, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэн энэ асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна. | 1. Нутгийн захиргаа, төрийн бус байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлөөс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажлын явц, үр дүнд төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулан хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгнө.<br>2. Иргэдийг олон нийтийн байцаагч, урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах ажлыг сайжруулах арга хэмжээ авна.<br>3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, санал боловсруулна.<br>4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна.<br>5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Хууль зүй , дотоод хэргийн сайдын төсвийн багцад оруулан төлөвлөж, Зохицуулах зөвлөлөөс төв, орон нутагт хуваарилан санхүүжүүлдэг журамд шилжих асуудлыг судална.<br>6. Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд туслах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг Албан бус сургалтын төв, Хүний эрхийн боловсролын төв болон бусад Төрийн Бус Байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж дэмжлэг үзүүлнэ. | 2005 оноос эхлэн 2 жилд 1 удаа<br>2006-2008<br>2005<br>2006<br>2005–2008<br>2005–2007 | С.Батболд<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Н.Баяртсайхан<br>Д.Одбаяр |
| 341 | 8.1.5 | Цагдаагийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулна. | 1. "Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын явц, үр дүнд жил бүр хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгнө. | Жил бүр | Д.Одбаяр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Тухайн нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажлын явц, үр дүнг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын зөвлөлийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа хэлэлцэн, тодорхой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх үйл ажиллагаар хэвшүүлнэ. | 2005–2008 | Д.Одбаяр Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 342 | 8.1.6 | Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас торгуулийг бэлэн мөнгөний хэлбэрээр оногдуулж байгаа журмыг өөрчилж, төлбөр тооцоог бэлэн бусаар хийх асуудлыг судалж, шийдвэрлэнэ. | 1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас торгуулийг мөнгөний бэлэн бус хэлбэрээр оногдуулж, тооцож байгаа бусад орны туршлагыг судалж санал боловсруулна. | 2006 | Д.Одбаяр |
| 343 | 8.1.7 | Хууль хяналтын байгууллагад ажиллагсдын цалин, хангамжийг нэмэгдүүлж, тэдэнд тавих хуулийн шаардлагыг чангатгана. | 1. Хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг сайжруулах талаар эрх зүйн орчин бий болгоно. | 2005 | Д.Одбаяр У.Хүрэлсүх |
| | | | 2. Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчдын ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авна. | 2005-2008 | У.Хүрэлсүх |
| 344 | 8.1.8 | Улс, үндэстэн дамнасан зэрэг шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажлын зохион байгуулалт, бэлэн байдлыг сайжруулж, үр дүнг дээшлүүлнэ. | 1. ОХУ-ын хил залгаа бүс нутгийн дотоод хэргийн байгууллагуудтай хил дамнан үйлдэгдэж буй гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл солилцох, харилцан хамтын ажиллагаар эрчимжүүлнэ. | 2005–2008 | Д.Одбаяр |
| | | | 2. Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2006–2008 | Д.Одбаяр |
| 345 | 8.1.9 | Замын хөдөлгөөнд хяналт тавих телекамерийн хяналтын системийг бий болгож, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 1. Нийслэл хотод замын төлө хяналтын систем бий болгох чиглэлээр төсөл боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдэж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. | 2005–2008 | Д.Одбаяр Н.Баяртсайхан Нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Замын хөдөлгөөний хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд иргэдээс тавих хяналтыг сайжруулна. | 2005–2008 | Д.Одбаяр |
| | | | 3. Ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдыг хөдөлгөөний аюулгүй байдалд сургаж дадлагажуулна. | 2006-2008 | Ө.Энхтүвшин Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 346 | 8.1.10 | Бие хүний өгөгдөл, гарын хурууны хээ, нүдний цэцгийн тусгалын мэдээллийн улсын нэгдсэн сан байгуулах асуудлыг судалж санал боловсруулна. | 1. Монгол Улсын иргэдийн гар, хурууны хээний нэгдсэн санг тэдний сайн дурын үндсэн дээр бий болгох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг судалж санал боловсруулна. | 2005 | Д.Одбаяр |
| | | | 2. Аймаг, нийслэлийн цагдаагийн байгууллагад гар, хурууны хээний "Папилон" систем нэвтрүүлэх асуудлаар төсөл боловсруулж шийдвэрлэнэ. | 2006 | Д.Одбаяр Н.Баяртсайхан |
| 347 | 8.1.11 | Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч, | 1. Цагдаагийн автомашины парк шинэчлэлтийн төслийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2005–2008 | Д.Одбаяр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | энэ чиглэлээр бий болсон өр төлбөрийг барагдуулж байх зохистой механизм бүрдүүлнэ. | 2. Уг судалгааг үндэслэн төсөв, гадаадын зээл тусламж, татвар, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг нээлттэй болгох чиглэлээр холбогдох арга хэмжээг авна. | 2007 | Н.Баяртсайхан<br>Л.Одончимэд |
| 356 | 8.1.20 | Төрийн албан хэрэг хөтлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож, архивын салбарт тоон мэдээллийн системийг нэвтрүүлэн архивын байрны хадгалалт, хамгаалалт, дохиоллын системийг үе шаттайгаар сайжруулна. | 1. Төрийн албан хэрэг хөтлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно. | 2005–2007 | Д.Одбаяр |
| | | | 2. Архивын байрны хадгалалт, хамгаалалт, дохиоллын системийг үе шаттайгаар сайжруулна. | 2005–2008 | Д.Одбаяр |
| | | | 3. Цагдаагийн байгууллагын төрөлжсөн архивыг бий болгож, зориулалтын байрны асуудлыг шийднэ. | 2005–2008 | Д.Одбаяр |
| | | | 4. Төрийн байгууллагуудын архивын баримтын эрэлт-хайлтыг боловсронгуй болгох үүднээс баримтыг тоон системд шилжүүлж эхэлнэ, нэгдсэн сан үүсгэнэ. | 2005-2007 | Д.Одбаяр |
| | | | 5. Төрийн архивуудыг галын болон аюулгүйн дохиоллын хамгаалалттай болгох зорилтыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Д.Одбаяр |
| | | | 6. Байнга хадгалах баримт бичгийг хадгалалтын олон улсын стандартын шаардлагыг хангасан цаасан дээр үйлдэх, буулгах ажлыг зохион байгуулж хэвшүүлнэ. | 2005-2007 | Д.Одбаяр |
| | | | 7. Төрийн архивуудад тохиолдож болох гэнэтийн осол, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ. | 2005-2007 | Д.Одбаяр |
| | | | 8. Гадаад хэргийн архивын ажлын арга зүй, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь сайжруулах, тэргүүн туршлага, олонт амжилтыг архивын ажилд нэвтрүүлнэ. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 9. Гадаад хэргийн архивыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах ажлыг өөрийн хүч хөрөнгө болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ. | 2004-2008 | Н.Энхболд |
| | | | 10. Гадаад хэргийн архивын зохион байгуулалтыг боловсронгуй болгож, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, үйл ажиллагааг автоматжуулж, програм хангамжтай болгон эрэлт хайлтын автоматжуулсан сан байгуулна. | 2004-2008 | Н.Энхболд |
| 357 | 8.1.21 | Хуульчдын боловсрол, мэдлэг чадвар, ёс зүйд тавих шаардлагыг өндөржүүлж, тэдгээрийн давтан сургалт, сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгоно. | 1. Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Д.Одбаяр |
| | | | 2. Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчийг зах зээл хөгжсөн өндөр хөгжилтэй орнуудад төрийн зардлаар урт, богино хугацааны сургалтад хамруулна. | 2006-2008 | Д.Одбаяр |
| | | | 3. Хуульчдын сонгон шалгаруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна. | 2005-2006 | Д.Одбаяр |
| | | | 4. Хуульчдын болон төрийн зарим албан хаагчийн мэдлэг чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх үргэлжилсэн, давтан сургалтыг зохион байгуулна. | 2005–2007 | Д.Одбаяр |
| | | | 5. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн хуульч /цагдаа, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгч г.м/ бэлтгэх, давтан сургах арга хэмжээ авна. | 2005-2007 | Д.Одбаяр<br>М.Энхсайхан<br>Л.Одончимэд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 358 | 8.1.22 | Мал хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх асуудалд эрс өөрчлөлт гаргана. | 1. Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх үүрэгтэй сумын хэсгийн төлөөлөгчийг унаалга, бусад шаардлагатай техник, хэрэгслээр хангах арга хэмжээ авна. | 2006-2008 | Д.Одбаяр<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Бусдын өмчийг хулгайлах болон мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд тавих иргэний хяналтыг өндөржүүлнэ. | 2006–2008 | Д.Одбаяр<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Архаг архидалтыг эмчлэх, эрүүлжүүлэх асуудлыг судлан боловсруулж холбогдох байгууллагад оруулна. | 2006-2008 | Д.Одбаяр<br>Л.Гундалай |
| | | | 4. "Архидан согтуурах, мал хулгайлах явдалтай хийх тэмцэлд иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, архидан согтуурахтай тэмцэх сан, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх санг дэмжих ажлыг зохион байгуулна. | 2006-2008 | Д.Одбаяр,<br>Н.Баяртсайхан,<br>Аймаг, нийслэлийн засаг дарга |
| | | | 5. "Мал хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх асуудлаар бүх нийтийг хамруулсан арга хэмжээ, удирдах ажилтны зөвлөгөөнийг жил тутам, бүсчилсэн семинарыг хоёр жил тутамд зохион байгуулж, энэ чиглэлээр зохиож байгаа ажлыг жил бүр дүгнэн мэдээлж байна. | 2006-2008 | Д.Одбаяр,<br>Д.Тэрбишдагва,<br>Аймаг, нийслэлийн засаг дарга |
| | | | 6. Мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загвар боловсруулж мөрдүүлнэ. | 2004-2005 | Д.Тэрбишдагва<br>У.Хүрэлсүх |
| | | | 7. Наркологийн төвийг бие даалган, эрүүлжүүлэх албад болон сайн дурын эмчилгээ, хордлого тайлах төв зэргийг нэгдсэн удирдлагатай болгох, Мааньт дахь албадан эмчилгээний газрыг өргөтгөх, аймаг дундын албадан эмчилгээний газруудыг бий болгох, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжинэ. | 2005-2008 | Л.Гундалай<br>Д.Одбаяр |
| | | | 8. "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлтэд тавих хяналтыг сайжруулна. | 2006-2008 | Д.Одбаяр<br>У.Хүрэлсүх |
| **8.2. Улсын хил хамгаалалтын чадавхийг бэхжүүлж хүн хүч, техник, технологи, санхүүгийн хүчин чадлыг сайжруулж, аюулгүй байдлыг хамгаалах тусгай байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 359 | 8.2.1 | Хил хамгаалалтын ажилд онцгой анхаарал хандуулж, "Дархан хил" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор "Дархан хил" хөтөлбөр боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ. | 2005–2008 | Д.Одбаяр |
| 360 | 8.2.2 | Хил хамгаалах хүчний техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. | 1. Хилийн харуулыг мотоцикль, заставыг суудлын авто машин, отрядь, ангиудыг тээврийн авто машинаар үе шаттайгаар хангана. | 2006-2008 | Д.Одбаяр |
| | | | 2. Заставын 1 хилчинг 3.5-аас доошгүй унаалгаар хангана. | 2006-2008 | Д.Одбаяр |
| 361 | 8.2.3 | Хилийн зөрчил, малын хулгай ихтэй хилийн хэсэгт хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлнэ. | 1. Хөвсгөл аймгийн ОХУ-ын Тува Улстай хиллэдэг хэсэгт хилийн застав 2-ыг нэмж байгуулна. | 2006-2008 | Д.Одбаяр |
| | | | 2. Хөрш орнуудтай хилийн асуудлаар хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлж, хилийн асуудлыг шуурхай зохицуулах зорилгоор БНХАУ-ын Хөх хотод хилийн албан ёсны төлөөлөгч суулгах, ОХУ-ын Кызылийн консулын орон тоонд хилийн мэргэжлийн ажилтан ажиллуулна. | 2005–2008 | Д.Одбаяр<br>Н.Энхболд |
| 362 | 8.2.4 | Хил хамгаалалтад сансрын холбоо, тоон мэдээллийн технологийг өргөн ашиглана. | 1. Зарим отрядуудыг "Весат" системийн холбоогоор холбоно. | 2006-2007 | Д.Одбаяр<br>С.Батболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. "Иргэний бүртгэл паспорт хяналтын нэгдсэн сүлжээ" төслийн хүрээнд хилийн боомтуудыг улсын хилээр нэвтрэгсдийн бүртгэл хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбоно. | 2006-2008 | Д.Одбаяр |
| 363 | 8.2.5 | Хил хамгаалагчдын шилжилт хөдөлгөөн хийх чадварыг эрс нэмэгдүүлж, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. | 1. Усан хилийн хамгаалалтыг сайжруулж орчин үеийн техник хэрэгслээр хангаж, материаллаг баазыг бий болгоно.<br>2. Хилийн боомтуудыг баримт бичгийн хяналт шалгалтын орчин үеийн техник хэрэгслээр хангана.<br>3. Дорнод аймгийн хилийн хэсгийн өргөст утсан хашааны модон шонг төмөр бетон шонгоор сольж, Дорноговь, Сүхбаатар аймгийн хилийн хэсгийн өргөст утсан хашааны хуучирсан модон шонг шинэчлэнэ.<br>4. Улсын хил хамгаалалтад ашиглаж байгаа зарим инженерийн байгууламжуудад их засвар хийх, улсын хил рүү ойртуулан нүүлгэн шилжүүлнэ. | 2006-2008<br>2006-2008<br>2006-2008<br>2006-2008 | Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр<br>Д.Одбаяр |
| 364 | 8.2.6 | Хүний нөөцийн хөгжилд онцгой анхаарч, хилчдийн ахуй амьдралыг дээшлүүлнэ. | 1. Хүний нөөцийн хөгжилд онцгой анхаарч мэргэжилтэй хилчин бэлтгэх, давтан бэлтгэх, тогтолцоог боловсронгуй болгоно.<br>2. Хилчдийн ахуй хангамж, нийгмийн асуудлыг сайжруулна. | 2006-2008<br>2006-2008 | Д.Одбаяр<br>Д.Одбаяр С. Батболд |
| 365 | 8.2.7 | Улсын хил хамгаалалтад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хилийн хязгаар нутагт амьдарч буй иргэдэд төрийн нийтлэг үйлчилгээг хүргэхэд түлхүү анхаарна. | 1. Хилийн хязгаар нутагт амьдарч байгаа иргэдэд төрийн нийтлэг үйлчилгээг хүргэх ажлыг сайжруулах арга хэмжээ авна. | 2005–2008 | С.Батболд Ө.Энхтүвшин Л.Гундалай Аймгийн Засаг дарга |
| 366 | 8.2.8 | Хүний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд терроризм, бусад аюул заналтай тэмцэх талаар олон улсын хэмжээнд тавьж буй хүчин чармайлтыг дэмжихийн зэрэгцээ үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 1. Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан хамтын ажиллагааг сайжруулах, терроризмтэй тэмцэх үүрэг бүхий нэгж, бүтцийг бий болгож, тэнд ажиллагсдыг сургаж дадлагажуулна.<br>2. Терроризмтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл солилцох орон тооны бус зөвлөлийг байгуулах, уг зөвлөлийн ажиллах холбогдох эрх зүйн баримт бичгийг батлуулж мөрдүүлнэ. | 2005–2008<br>2005-2006 | М.Сономпил Д.Одбаяр С.Батболд<br>С.Батболд Д.Одбаяр |
| 367 | 8.2.9 | Тагнуулын албыг өндөр мэргэшилтэй албан хаагчдаар бүрдүүлэхэд анхаарч, гүйцэтгэх ажилд шинэ техник хэрэгсэл, аргыг нэвтрүүлнэ. | 1. Тагнуулын ерөнхий газрын дээд сургуульд тагнуулын дээд мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэж, ажилтнуудыг магистрын сургалтанд хамруулна.<br>2. Энгийн мэргэжлээр төгссөн шинэ ажилтнуудыг Тагнуулын ерөнхий газрын дээд сургуульд 6 сараас доошгүй хугацаагаар мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээ авна.<br>3. Түншийн харилцаатай гадаадын тусгай албадын дээд сургууль, академийн үндсэн анги болон богино хугацааны сургалтад үндсэн ажилтнуудаас жилд 40 хүнийг сургаж мэргэшүүлнэ. | 2005-2008<br>2005-2008<br>2005-2008 | С.Батболд<br>С.Батболд<br>С.Батболд |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 6